




НЭГДСЭН
ҮНДЭСТНИЙ
БАЙГУУЛЛАГА
МОНГОЛ УЛС



МОНГОЛ УЛС ХӨГЖЛИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ



2023
ШИНЭЧИЛСЭН

АГУУЛГА

Хураангуй тойм.....	2
1. НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ.....	7
1.1 Макро-эдийн засгийн нөхцөл байдал.....	8
1.2 Монгол Улсын Хүний хөгжлийн асуудал.....	11
1.3 Мансууруулах бодис, гэмт хэрэг.....	12
1.4 Дэлхий дахинд өрнөж буй үйл явц, Монгол Улсад үзүүлэх нөлөө.....	15
1.5 Цахим хөгжил, хөдөө аж ахуй, бусад ахиц дэвшил.....	16
2. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, БАЙГАЛЬ ОРЧИН.....	18
2.1 Биологийн олон янз байдлыг хамгаалах: Ой, тусгай хамгаалалттай газар нутаг, цөлжилт.....	18
2.2 Бохирдол.....	20
2.3 Уур амьсгалын өөрчлөлт.....	21
2.4 Гамшгийн эрсдэл.....	23
3. УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ.....	25
3.1 Бодлого, засаглал, институтцийн өөрчлөлт.....	26
3.2 Хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд.....	29
4. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ.....	33
4.1 Бүс, орон нутгийн хөгжлийн асуудал.....	34
4.2 ТХЗ-ын хэрэгжилтийн хоёр дахь удаагийн ҮСДИ-ийн үр дүнг ашиглахдаа анхаарах зарим асуудал, цаашдын алхам.....	36
5. ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХ ЗАРЧИМ, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ.....	37
6. ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТЭД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ.....	43
6.1 Хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэл, үндэсний зорилт, ТХЗ-ын хурдасгуурууд.....	44
6.2 ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бусад үйл ажиллагаа.....	46
Дүгнэлт.....	47
Товчилсон үгс.....	48

ХУРААНГУЙ ТОЙМ



ХУРААНГУЙ ТОЙМ

2021 онд нийтэлсэн Монгол Улсын Хөгжлийн төлөв байдлын шинжилгээ (ХТБШ) нь макро түвшинд хийсэн өргөн хүрээтэй судалгаа шинжилгээний үр дүнг агуулсан байдаг. Улмаар уг шинжилгээг 2022 онд нэмэлт шинэ мэдээллээр баяжуулан шинэчилж нийтэлсэн. Түүний нэгэн адил энэхүү танилцуулж буй 2023 оны Монгол Улсын ХТБШ нь 2023 онд шинээр өрнөсөн үйл явц, ололт амжилтыг судлахын зэрэгцээ 2021, 2022 оны ХТБШ-нд тусгагдаагүй зарим асуудалд түлхүү дүн шинжилгээ хийхэд чиглэсэн. Энэ утгаараа 2023 оны шинэчилсэн ХТБШ нь 2021 оны ХТБШ-ний арга зүй, агуулгыг хэвээр үргэлжлүүлэхийн зэрэгцээ илүү шинэлэг нэмэлт мэдээллээр арвижуулсан шинжилгээ болсон.

Дэлхийн геополитикийн нөхцөл байдал амаргүй байгаа хэдий ч Монгол Улсын эдийн засаг 2023 онд 7 хувиар өсч чамлахааргүй амжилт гаргалаа. Макро эдийн засгийн бүх үзүүлэлт эерэг гарахад ганц зах зээл рүү чиглэсэн (нийт экспортын 91,4 хувь) урсгалтай ашигт малтмал, үнэт металийн экспорт (улсын нийт экспортын 91.6 хувь) нөлөөлжээ. Экспортод түшиглэсэн эдийн засгийн энэхүү тэнцвэргүй өсөлт нь Монгол Улс эдийн засгаа яаралтай төрөлжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна. Монгол Улсын хувьд ноолуур, мах, ноос зэрэг бусад төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл нь уул уурхайн бус салбарын эдийн засгийг төрөлжүүлэхэд хамгийн чухал салбар юм. Монгол Улс цахим худалдааг дэмжих, төрийн үйлчилгээг цахимжуулах (e-Mongolia 3.0), хүнсний аюулгүй байдлыг хангахын тулд хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх зэрэг олон чиглэлээр цахим хөгжлийн шинэ хандлагад шилжих хүчин чармайлтаа үргэлжлүүлж байна. Геополитикийн хөгжлийн нөлөөнд өртөмтгий, далайд гарцгүй хөгжиж буй орон болох Монгол Улс нь Венийн Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг олон улсын өмнө хүлээх үүрэг амлалтад идэвхтэй оролцож ирсэн.

КОВИД-19 цар тахлын уршгаар Монгол Улсын Хүний хөгжлийн индекс (ХХИ) 2021 онд 0.730 болж буурсаар 2013 оны түвшинд (дэлхийн болон

бүс нутгийн түвшинд) ойртсон нь Тогтвортой хөгжлийн чиглэлээр гарч байсан ололт амжилтын багагүй хэсгийг ухрахад хүргэсэн. Монгол Улсын ХХИ 2022 онд 0.741-д хүрч дэлхийн 193 орноос 96-д эрэмбэлэгдэж байгаа бөгөөд 2023-24 онд буцаж сэргэнэ хэмээн таамаглаж байна. Үндэсний статистикийн хороо (ҮСХ), Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2022 онд 27.1 хувьтай байв. Монгол Улсын нийт хүн амын 7.3 хувь нь (2021 онд 243 мянган хүн) олон хэмжээст ядууралд өртсөн, 15.5 хувь нь (2021 онд 519 мянган хүн) олон хэмжээст ядууралд өртөх эрсдэлтэй ангилалд багтаж байна. Монгол Улсад үйлдэгдэж буй гэмт хэргийн тухайд хар тамхины наймаа, хэрэглээ нэмэгдэж байгаа төдийгүй кибер гэмт хэрэг, тэр дундаа кибер орон зайд болон үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн тохиолдлууд өсч байна.

Биологийн олон янз байдлыг хамгаалах чиглэлд дэлхийн дулаарал, хуурайшилтаас үүдэлтэй ойн түймэр ихэсч ойн нөөц хомсдох сорилтууд Монгол Улсын өмнө тулгарч байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалж, сайжруулах зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг Монгол Улс санаачлан хэрэгжүүлж байна. Монгол Улс нь Онон-Балжийн байгалийн цогцолборт газрыг НҮБ-ын БШУСБ (UNESCO)-ын Шим мандлын дархан цаазат сав газрын бүртгэлд бүртгүүлэх хүчин чармайлт гарган амжилттай ажилласан. Тус улсын нутаг дэвсгэрийн нэлээд хэсэгт цөлжилт ажиглагдаж байгаад мал сүргийн тоо толгойн өсөлт нөлөөлж байна. Монгол Улс НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг 2026 онд эх орондоо зохион байгуулна.

Хэдийгээр Монгол Улс дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтын дөнгөж 0.1 хувийг бүрдүүлж байгаа ч уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд багагүй өртөж байна. Монгол Улс нь 2030 он гэхэд дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад оруулах Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо (ҮТХН) 27.2 хувь (нөхцөлт) буюу

22.7 хувь (нөхцөлт бус) хэмээн ахиулан шинэчилж өргөн барьсан. Түүнчлэн Монгол Улс нь жил бүр ДНБ-ийхээ нэг хувийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэхэд зарцуулах үүрэг хүлээсэн бөгөөд үүнд ойролцоогоор 11.5 тэрбум ам.доллар шаардлагатай.

Уур амьсгалын өөрчлөлтөд Монгол орон ихээхэн өртөмтгий байгаа нь зуд турханы давтамж нэмэгдэж, малчдын амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд тусч буй сөрөг нөлөөллөөс ажиглагдаж байна. 2023/2024 оны өвөл тус улсын нутаг дэвсгэрийн 90 хувь нь зудын өндөр эрсдэлтэй тулгарч, 190 мянган малчин өрхийн амьжиргаанд хүчтэй нөлөөлөх төлөвтэй байна. Монгол Улс нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Даян дэлхийн метаны амлалт зэрэг олон улсын санаачилгад нэгдсэн. Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний салбарт асар их нөөцтэй бөгөөд 2030 он гэхэд нийт эрчим хүчний хэрэглээнд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувийг 30 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Эдгээр хүчин чармайлтын хажуугаар хуванцар бохирдол, агаарын бохирдол зэрэг сорилтууд тулгарсаар байна. Монгол Улс нэг хүнд ногдох хуванцар хог хаягдлын үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэгч орнуудын тоонд орж байгаагийн зэрэгцээ түлээ, нүүрсний хэрэглээтэй холбоотой өвлийн улирлын агаарын бохирдлын асуудал ч мөн хүнд сорилт хэвээр байна.

2023 онд Монгол Улсын улс төрийн өнгө төрхөд нөлөөлсөн гол үйл явдал, хүчин зүйлд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, сонгууль, улс төрийн нам, боловсролын тогтолцоотой холбоотой хуулиудыг шинэчлэн баталсан, авилгалын талаар өрнөсөн дуулиан шуугиан, төрийн өндөр дээд хэмжээний айлчлалууд зэрэг багтана. Сонгуулийн тогтолцоонд орсон өөрчлөлт шинэчлэлт, улс төрд нэр дэвшигчдийн жендэрийн тодорхой квот тогтоох, улс төрийн намуудын санхүүжилтийн ил тод байдлыг хангах, авилгатай тэмцэх зэрэг чиглэлээр засгийн газраас гаргаж буй хүчин чармайлтын талаар судалж энэхүү шинжилгээнд тусгасан. Түүнчлэн, авлигачдыг мэдээлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, төрийн албанд хууль бусаар томилогдсон хүмүүсийг илрүүлэх, авлигын гэмт хэрэгтнүүдийг эргүүлэн авчирч хариуцлага хүлээлгэх, хууль бус хөрөнгийг илрүүлэн шилжүүлэн авчрах зэрэг авилгатай тэмцэх “Таван-Ш” ажиллагаанд хийсэн дүн шинжилгээг энэхүү тайланд мөн тусгасан болно. Монгол Улсын гадаад бодлого нь үндэснийхээ үнэт зүйлийг эрхэмлэж, эдийн засгаа төрөлжүүлэхийн тулд хөрш зэргэлдээ орнууд болон гуравдагч хөршүүдтэйгээ харилцах найрсаг харилцаагаа тэнцвэртэйгээр бэхжүүлэхийг зорьж байна.



Монгол орон уур амьсгалын өөрчлөлтөд ихээхэн өртөмтгий орнуудын нэг.
@ НУБ-ын СЗГ

Үндэсний тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгох чиглэлээр Монгол Улс хүчин чармайлт гарган ажиллаж байна. Энэ нь тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн үйл ажиллагааг зогсоож, тус зөвлөлийн чиг үүргийг Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ) болон Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд шинээр байгуулагдсан Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт шилжүүлснээр илэрч байна. 2020 онд Монгол Улсын Их Хурлаас тогтоол гарч, арван жилийн хугацаанд долоон сэдэвчилсэн хөтөлбөр боловсруулах үүргийг Засгийн газарт даалгасан. Эдгээрээс 2021 онд хэрэгжсэн ажил нь Шинэ сэргэлтийн бодлого юм. Үлдсэн зургаан хөтөлбөрийг ЭЗХЯ-ны боловсруулсан ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдтэй уялдуулан боловсруулж, эцэслэх ажил хийгдэж байна.

Хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа тасралтгүй нэмэгдэж, сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд хөгжлийн гол бэрхшээлийн нэг болсоор ирсэн. Бодлогын уялдаа холбоогүй, бодит бус шийдвэрүүдийн уршгаар нийслэл Улаанбаатар хот хөгжлийн цор ганц төв болсон. Тус улсын нийт хүн амын тал орчим (47 хувь) нь амьдарч байгаа бөгөөд дээд боловсрол, сургалтын байгууллагын 90 гаруй хувь, худалдаа үйлчилгээний 80 гаруй хувь нь Улаанбаатар хотод төвлөрч байна¹.

Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрийг дэмжих үүднээс дэд бүтцийн салбар, тэр дундаа зам, тээврийн салбарын бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон байдаг. Гэсэн хэдий ч төр засгийн зүгээс бодитой, тууштай, үр дүнд чиглэсэн төсөв санхүү, татвар, хөрөнгө оруулалтын бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд бүс нутгийн хэмжээнд өсөлтийг хангах тэргүүлэх чиглэлийн салбар, төслүүдийг тодорхойлсон зураглал гаргаж нарийвчилсан дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлага байна. Ингэснээр аймаг орон нутгийн хот суурин газруудад ажлын байр бий болох, нийгмийн чанартай үйлчилгээ үзүүлэх таатай орчныг бүрдүүлж бүс нутгийн хөгжлийг дэмжих боломж бүрдэнэ. Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжих жил” болгон зарлаж, “бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг шинэчлэн боловсруулж УИХ-ын 2024 оны хаврын ээлжит чуулганаар батлуулахаар ажиллаж байна.

Хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур (хамгийн бага орлоготой 40 хувьд хамрагдаж байгаа) өрхөд амьдардаг, боловсрол тааруу, дунд эргэм насны эрэгтэйчүүд хөгжлийн хувьд хамгийн орхигдох эрсдэлтэй бүлэгт орж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, дотоодын шилжигчид, хүүхдүүд, орон гэргүй тэнэмэл хүмүүс (боловсрол муутай, архинд донтсон, гэр бүлийн хүчирхийллийн золиос болсон, засан хүмүүжүүлэх газраас суллагдсан, асрамжийн газраас насанд хүрээд гарсан) зэрэг хүн амын бүлгүүд анхаарлын гадна орхигдох хамгийн өндөр эрсдэлтэй байна. Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй нийт 115,115 хүн амьдарч байгаа тооцоо байна. Тэд нийгмийн хөгжлөөс орхигдох эрсдэл хамгийн өндөр төдийгүй эмзэг бүлэгт хамрагдсан хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрхүүдийн дийлэнх нь хамгийн бага орлоготой өрхүүдийн тоонд орж байна.

Жендэрт суурилсан хүчирхийллийн түвшин өндөр, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо хязгаарлагдмал байгаа зэрэг нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад саад тээг болж байна. Монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь амьдралынхаа аль нэг үед хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртөж байсан бөгөөд байнгын хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 31.2 хувь нь дотны хамтрагчийнхаа зүгээс бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан тухай судалгааны тайланд өгүүлжээ. ҮСХ болон НҮБ-ын Хүн амын сангийн хамтран явуулсан энэхүү судалгаагаар жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх хамгаалалтын хүчин зүйлс (гэр бүлийн бат бөх харилцаа) болон жендэрт суурилсан хүчирхийлэлд хүргэж болзошгүй эрсдэлт хүчин зүйлс (бага балчир насандаа хүчирхийлэлд өртөх)-ийг тодорхойлсон байна. Энэ нь жендэрт суурилсан хүчирхийлэл гарч буй үндсэн шалтгааныг таслан зогсоох хариу арга хэмжээний механизмыг бэхжүүлэх үр дүнтэй стратегийг боловсруулах чухал үндэслэл болж байна.

Монголын залуучууд, ялангуяа хөдөө орон нутгийн хүн амын цөөнгүй хэсэг нь дижитал хуваагдалтай нүүр тулж байна. Сургууль завсардалт, ажилгүйдэл, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, эрт гэр бүлийн амьдралд орох зэрэг эрсдэлд өсвөр үеийнхэн, залуучууд, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд илүү өртөмтгий байна.

¹ ҮСДИ 2023 Монгол Улс <https://hlpf.un.org/sites/default/files/vnrs/2023/VNR%202023%20Mongolia%20Report.pdf>

Монгол Улс хүн амынхаа өвөрмөц бүтцийн чадавхийг бүрэн дүүрэн ашиглахын тулд залуучуудад ур чадвар эзэмшүүлж, үр бүтээлтэй, зохистой хөдөлмөр эрхлэх хангалттай боломж нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай. Монгол Улсын төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогын хүрээнд сүүлийн үед хийсэн бүтцийн өөрчлөлтөөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар болгон өөрчилсөн бөгөөд залуучуудын хөгжлийн асуудлаарх тодорхой чиг үүргийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа шинээр байгуулагдсан Залуучуудын хөгжлийн асуудал эрхэлсэн алба хариуцан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газар нь 2023 онд болсон ТХЗ-ын улс төрийн дээд хэмжээний чуулганд ТХЗ-ын хэрэгжилтийн талаарх хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэл (ҮСДИ)-

ээ боловсруулж танилцуулсан. Энэхүү ҮСДИ-ийн дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Засгийн газар нь үндэсний хөгжлийн тэргүүлэх гурван зорилт, ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах 12 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үндэсний хөгжлийн тэргүүлэх гурван зорилт нь ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах 12 тэргүүлэх чиглэлийг баталж, хэрэгжүүлэх, 2030 он гэхэд үндэсний ядуурлын түвшинг 15 хувь хүртэл бууруулах, институтцийн тогтолцоог бэхжүүлж ТХЗ-ын хурдасгуур зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг юм.

Тус шинжилгээнээс харахад НҮБ-ын 2023-2027 оны ТХХАХ-ний хүлээгдэж буй үр дүнгийн зорилтууд нь ТХЗ-ын 12 хурдасгуур зорилтуудтай нийцсэн байна. Гэхдээ Монгол Улс дахь НҮБ-ын хэрэгжүүлж буй хөтөлбөр, төслүүдийг эдгээр ТХЗ-ын хурдасгуур зорилтуудтай уялдуулах нь чухал байна.



Улс орныхоо хөгжлийг түүцээлэх асар их хүч нөөц залууст бий. @ НҮБ-ын СЗГ

1 НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ



1.1 Макро-эдийн засгийн нөхцөл байдал

Монгол Улсын эдийн засаг 2023 онд сайн байлаа. Үүнийг макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд ч илэрхийлж байна. 2023 онд дотоодын нийт бүтээгдэхүүний (ДНБ) жилийн дундаж өсөлт 7 хувьд хүрч, төлбөрийн тэнцлийн урсгал данс 2023 онд 244.5 сая ам.долларын ашигтай гарч, гадаад худалдааны нийт эргэлт 24.4 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарсан зэргийг Зураг 1 үзүүлж байна. Гэвч эдгээр үзүүлэлт нь нүүрсний экспортын өсөлтөөс ихээхэн хамааралтай байгаа нь цаашдаа энэ хандлага урт хугацаанд хэвээр үргэлжлэх эсэхэд болгоомжтой хандах хэрэгтэй. Дэлхий нийтээр ч нүүрсний хэрэглээнээс татгалзах болсон.


2023 оны ихэнх саруудад инфляц хоёр оронтой тоогоор илэрхийлэгдэж өндөр хэвээр байсан ч 2023 оны 12-р сард нэг оронтой тооруу орж буюу 7.9 хувь болж саарсан (Зураг 2). Гадаад валютын улсын нөөц 2023 оны 12-р сарын эцэст 4 тэрбум 918 ам.долларт хүрч ихээхэн нэмэгдсэн байна (Зураг 3). Монгол төгрөгийн ам.долларын албан ханш 2023 оны туршид үргэлжлэн чангарсаар 2023 оны 12-р сарын төгсгөлд 3410 орчим төгрөг болж чангарсан байна.

Зураг 1. ДНБ, гадаад худалдааны тэнцэл, урсгал данс (сая ам. доллараар)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 1212.mn (ДНБ, оны үнээр)

Зураг 2. Инфляц (хувиар)



(Эх сурвалж: УЦХ, Сарын статистикийн бюллетень, 2024 оны 1-р сар)

Зураг 3. Гадаад валютын улсын нөөц (сая ам. доллар)




(Эх сурвалж: Монгол Банкны цахим хуудас, 2024 оны 1-р сарын 10)

2023 оны эдийн засгийн өсөлтөд экспортын гол салбар болох уул уурхай, олборлох салбар чухал үүрэг гүйцэтгэсэн хэвээр байв. Экспортын бүтээгдэхүүний 91-ээс илүү хувийг ашигт малтмал, нүүрсний экспорт бүрдүүлж байна. Үүний зэрэгцээ нийт экспортын 91 гаруй хувийг зөвхөн БНХАУ руу хийжээ. Эдийн засаг өсч байгаа нь сайшаалтай хэдий ч, уул уурхайн салбар (Зураг 4) болон ганцхан

зах зээлээс гүнзгий хамааралтай байгаагийн зэрэгцээ БНХАУ руу чиглэсэн нүүрсний экспортоос хэт хамааралтай байгааг онцлон тэмдэглэх нь чухал юм. Энэ нь эдийн засгийн тогтвортой, тэсвэртэй байдлыг урт хугацаанд хадгалахын тулд эдийн засгийг төрөлжүүлэх шаардлага нэн чухал байгааг илэрхийлж байна.

Зураг 4. Монгол Улсын Экспортын бүтэц (сая ам. доллараар, сонгосон жилүүдээр)




Эх сурвалж: YCX, Сарын статистикийн бюллетень, 2024 оны 1-р сар.

Уул уурхайн бус салбаруудаас ноолуур, мах болон ноос үйлдвэрлэлийн бусад салбар нь экспортыг төрөлжүүлэхэд чухал салбар юм (Зураг 5-ыг үзнэ үү). Хамгийн сүүлийн үеийн буюу 2023 оны Олон улсын худалдааны төв (ОУХТ/ITC)-ийн Уул уурхайн

бус экспортын тэргүүлэх салбарын Үндэсний экспортын стратеги (ҮЭС/NES)-д эдгээр салбар дотроос экспортын төрөлжүүлэлтийг дэмжих өндөр боломж бүхий салбарт мах, махан бүтээгдэхүүн, ноолуур, ноолууран хувцас, жимсгэнэ, хушны

Зураг 5. Монгол Улсын Уул уурхайн бус экспортын тэргүүлэх арван салбар



Эх сурвалж: Монгол Улсын Гаалийн мэдээллээс, 2023 оны 1-9-р сар

самар, арьс ширэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг оруулсан байна. Түүнчлэн Үндэсний экспортын стратеги (ҮЭС/NES)-д мэдээллийн технологи, адал явдалт болон соёлын аялал жуулчлалыг экспортын үйлчилгээний гол салбар хэмээн тодорхойлсон. Эдгээр салбар нь 2021 онд Монголын ДНБ-ий 4 хувийг дангаар бүрдүүлжээ. Жижиг дунд үйлдвэрлэлийн салбар нь тус улсын нийт ажиллах хүчний 57 хувь, ДНБ-ий 17 хувийг бүрдүүлж байна². Жижиг аж ахуйн нэгжүүдийн экспортын өрсөлдөх чадвар, боловсруулах чадавхийг сайжруулснаар экспортын төрөлжүүлэлт, импортыг орлох, ялангуяа хөдөө аж ахуй-хүнсний салбарын хөгжилд бодитой хувь нэмэр оруулах боломж бүрдэнэ.

Бүс нутгийн хөгжиж буй эдийн засагтай бусад улс орнуудтай харьцуулахад Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2023 онд харьцангуй сайжирсан төдийгүй эдийн засгийн хэтийн төлөв нь ч тогтвортой хэвээр байна.³ Гэсэн хэдий ч түүхий эдийн олон улсын зах зээлийн тогтворгүй байдал, БНХАУ-ын сүүлийн үеийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хямрал зэрэг нь Монгол Улсын нүүрс, төмрийн хүдэр, зэс зэрэг ашигт малтмалын экспортод сөргөөр нөлөөлж болзошгүй байна.⁴

Монгол Улс өр зээлээ зохистойгоор удирдан өсөлт дэвшил гаргаж байгаагийн үр дүнд хөгжиж буй зах зээлд таатай байр суурь эзэлж байна. Монгол Улсын макро-өрийн дарамт суларч байгаа хэдий ч эрсдэл өндөр хэвээр байна. Дэлхий нийтээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хүлэмжийн хийн ялгаруулалт, шингээлтийн зөрүүг тэглэх хандлага руу шилжиж байгаагаас нүүрс болон түүнтэй адилтгах бүтээгдэхүүний экспортын хэмжээ аажмаар буурах хандлага ажиглагдаж байгаа учир цаашид Монгол Улс эдийн засгийн өсөлтөө тогтвортой хадгалах оновчтой арга замыг тодорхойлох шаардлага тавигдаж байна.

Монгол Улс дахь НҮБ нь Хамтарсан Ажлын Төлөвлөгөө болон хүлээгдэж буй үр дүнгийн дэд зорилтуудыг тодорхойлох, боловсруулах, хэрэгжүүлэхдээ эдийн засгийг төрөлжүүлэх, хүнсний үйлдвэрлэл, нэмүү өртгийн сүлжээ зэрэг хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэрлэл, дижитал хөгжил, Монгол Улсын Засгийн газраас ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгагч 12 тэргүүлэх чиглэлийн нэг хэмээн баталсан залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зэрэг асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай.

² <https://www.asiamoney.com/article/b1jx9t46m5grck/mongolia-smes-take-centre-stage#:~:text=The%20SME%20sector%20has%20long,nation's%20annual%20gross%20domestic%20product>

³ ОУВС-ын тооцоогоор 2024 онд Монгол Улсын эдийн засгийн өсөлт 4.5 хувь байх төлөвтэй байна. (<https://www.imf.org/en/News/Articles/2023/10/04/pr23335-mongolia-imf-executive-board-concludes-2023-article-iv-consultation-with-mongolia>)

⁴ АХБ, Ази тивийн Хөгжлийн төлөв байдал, 2023 оны 9-р сар.

1.2 Монгол Улсын Хүний хөгжлийн асуудал

Монгол Улсын хүний хөгжлийн асуудал нь эдийн засгийн өсөлт, экспорт, гадаадын шууд хөрөнгө оруулалт (ГШХО), БНХАУ-ын дотоод, гадаад эрэлт зэргээс шалтгаалсан нөхцөл байдлаас ихээхэн хамаарч байна. Улс үндэстний хүний хөгжил (эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны түвшин)-д гаргаж буй ахиц дэвшлийг хэмждэг Хүний хөгжлийн индекс (ХХИ 2023/24)⁵-ийн сүүлийн үеийн мэдээллээс харахад Монгол Улсын Хүний хөгжлийн индекс 2021 онд 2013 оны түвшинд хүрч буурсан байна. Гэсэн хэдий ч эргээд сэргэх зарим шинж илэрч байна. Монгол Улс нь Хүний хөгжлийн үзүүлэлт өндөртэй улс орнуудын тоонд орж байгаа бөгөөд 2022 онд дэлхийн 193 орноос 96-д жагссан. Тус улс нь бүс нутаг төдийгүй дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил урт хугацаанд хүний хөгжлийн чиглэлээр ахиц дэвшил гаргаж байгаа хэдий ч тэгш бус байдал гүнзгийрсэн хэвээр, хүний хөгжлийн хүрсэн түвшнээсээ ухрах үзэгдэл гарсан хэвээр байна. КОВИД-19 цар тахлын дэгдэлтийн үед хүний хөгжилд тулгарсан урвуу өөрчлөлт нь тогтвортой хөгжил, ялангуяа уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, дасан зохицоход чиглэсэн үйл ажиллагааг үргэлжлүүлэхэд ихээхэн ухраасан.

ХХИ 2023/24 оны мэдээллээс үзэхэд сүүлийн 30 жилийн хугацаанд тогтвортой өсч 2018 онд 0.754 буюу хамгийн өндөр түвшиндээ хүрч байсан Монгол Улсын ХХИ эдийн засгийн өсөлт, дундаж наслалт, сургуульд сурсан дундаж жил зэрэг үзүүлэлтүүдэд гарсан ухралтаас шалтгаалан 2021 онд 0.730 болж буурчээ. Гэсэн хэдий ч 2022 онд 0.741 болж бага зэрэг сэргэсэн. КОВИД-19 цар тахлаас өмнөх үед ХХИ-ийн өсөлтийг дагаад тус улсад ядуурлын түвшин, тэгш бус байдал буурч байсан. Үндэсний статистикийн хороо, Дэлхийн банкны судалгаагаар Монгол Улсын ядуурлын түвшин 2022 онд 27.1 хувьтай байв. Монгол Улсын 914200 орчим иргэн ядуурлын шугамаас доогуур, 346400 орчим хүн ядуурлын шугамд ойролцоо (ядуурлын шугам гэдэг нь насанд хүрсэн нэг хүний сарын хэрэглээ нь 418090 төгрөг буюу 123 ам. доллар юм) байна.⁶ Монгол Улсын Олон хэмжээст ядуурлын индекс (MPI)-ийг хамгийн сүүлд 2018 оны судалгааг үндэслэн тооцсон. Энэ судалгаагаар Монгол Улсын

нийт хүн амын 7.3 хувь нь (2023 онд 256 мянган хүн) олон хэмжээст ядууралд өртсөн, 15.5 хувь нь (2023 онд 543 мянган хүн) олон хэмжээст ядууралд өртөх эрсдэлтэй ангилалд багтаж байна. Олон хэмжээст ядууралд өртсөн хүмүүсийн ядуурлын гачигдлын оноо болох Монгол Улсын ядуурлын эрчим 38.8 хувь байна. Олон хэмжээст ядууралд өртсөн хүмүүсийн нийт хүн амд эзлэх хувь болох Олон хэмжээст ядуурлын индекс (ОХЯИ)-ийн утгыг гачигдлын эрчмээр хувиргавал 0.028 болж байна. Киргизстан, Туркменистан улсын ОХЯИ-ийн утга 0.001 байна⁷.

Тус улсын амьжиргааны өртөг тасралтгүй нэмэгдэж, инфляцын түвшин хоёр оронгоос буухгүй байгаа, зарим аймгуудад "зуд" нүүрлэж, хэд хэдэн аймаг тал хээрийн түймэр, үерийн гамшигт өртсөн зэрэг нь өмнө гаргасан хүний хөгжлийн ахиц дэвшил, ядуурал, тэгш бус байдлыг бууруулах чиглэлд гаргаж буй хүчин чармайлтад сөргөөр нөлөөлж байна. Дээр өгүүлсэнчлэн байгаль орчинд учруулж буй дарамт, экспортод тулгуурласан эдийн засгийн өсөлтөд нөлөөлж болзошгүй цочролыг тооцвол хүний хөгжлийн ирээдүй бүрхэг байна. Монгол Улсын байгаль орчинд учруулж буй нөлөөллийг тооцсон ХХИ 0.691 гарч байгаа нь бүс нутагтаа хамгийн доод үзүүлэлт болж байгаа төдийгүй тус улс байгаль орчинд хэт өндөр дарамт учруулж байгааг илэрхийлж байна.



Хүн бүр эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй.
@ НҮБ-ын Хүүхдийн сан

⁵ <https://hdr.undp.org/data-center/country-insights#/ranks>

⁶ <https://english.news.cn/20240207/b5418d17d73f4a2aa0961c8a83c17fbc/c.html>

⁷ <https://hdr.undp.org/system/files/documents/hdp-document/2023mpireportenpdf.pdf>

1.3 Мансууруулах бодис, гэмт хэрэг

2023 онд улсын хэмжээнд нийт 35,574 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оныхоос 234 (0.7%)-өөр өссөн байна.⁸ 2023 онд гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчийн тоо 24134 болж, өмнөх оноос 469 (2.0%)-өөр нэмэгджээ.⁹

Мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодисын тухай 1961, 1971, 1988 оны НҮБ-ын конвенцуудад Монгол Улс нэгдэн орсон. Монгол Улс 'Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль'-ийг 2002 онд баталснаар хар тамхи, мансууруулах бодисын хяналт, хууль эрх зүйн орчин бүрдсэн. Монгол Улсад хүний эрүүл мэндэд ноцтой хор хөнөөл учруулах хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгдэх болсон нь эрх баригчдын санааг зовоосон асуудал болж байна. Нэгэн цагт мансууруулах бодисын хэрэглээ гашиш, каннабисаар хязгаарлагдаж байсан бол сүүлийн үед хөрш зэргэлдээ орнуудаас метамфетамин зэрэг хүний биед маш хортой мансууруулах бодис зөөж Монголын зах зээлд худалдаалах тохиолдол олширч байна. Монгол Улс нь Зүүн хойд болон Зүүн Азийн орнууд руу хар тамхи, мансууруулах бодис дамжин өнгөрөгч орон болсон төдийгүй иргэд ч мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэгч, худалдаалагчийн төвшинд үнэлэгдэх болсон. КОВИД-19 цар тахлын дэгдэлтээс хойш Монгол Улс руу хар тамхи зөөвөрлөхөд тээвэр зуучлал, ачаа тээврийн компаниудыг ашиглах шинэ чиг хандлага бий болсон төдийгүй кибер орон зай ч мөн хар тамхины хууль бус худалдааны гол эх үүсвэрийн нэг болж байна. Монголын худалдан авагчид шуудангаар мансууруулах бодис тээвэрлэдэг диллерүүдтэй (Төв Азид байршилтай хэд хэдэн тохиолдол гарсан) холбогдон криптовалют ашиглан онлайнгаар гүйлгээ хийх тохиолдол ч гарчээ.

Монгол Улс 2008 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц (НҮБ-ын ҮДЗБГХЭК)¹⁰ болон түүний

гурван Протоколд нэгдсэн бөгөөд 2021 оны 11-р сард эхэлсэн конвенцийн хэрэгжилтийг нягтлан шалгах үйл явцад оролцсон. Хар тамхины наймаа, зэрлэг амьтдын худалдаа, байгалийн баялгийг хууль бусаар хил нэвтрүүлэх зэрэг үндэстэн дамнасан гэмт хэргийн тохиолдлууд Монгол Улсад гарч байна. Нэг грамм нь 150-200 ам.доллараар үнэлэгддэг метамфетамин худалдаалах зэрэг өндөр ашиг орлоготой мансууруулах бодис, хар тамхины худалдаа эрхэлдэг үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд хар тамхины наймаанд оролцох явдал улам олширч байна.

Монгол Улсад 2022 онд цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг 259 гэмт хэрэг бүртгэгджээ.¹¹ Монгол Улсын хүн амын интернэт, нийгмийн сүлжээний хэрэглээ Ази тивдээ дээгүүр ордог хэдий ч хүн амын дижитал бичиг үсгийн мэдлэгийн түвшин сайнгүй хэвээр байгаа нь Монгол Улсын иргэд олноороо цахим залилан, кибер гэмт хэргийн золиос болоход хүргэж байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр залилан мэхлэх, хувь хүний мэдээлэлд халдах гэмт хэрэг байнга гарч байгаа бөгөөд криптовалютаар холбоотой гэмт хэрэг ч Монгол Улсад нэмэгдэж байна. Байгаль орчны эсрэг 558 гэмт хэрэг 2022 онд бүртгэгджээ.¹² Монгол Улсад хууль бусаар ашигт малтмал олборлох, хууль бусаар мод бэлтгэх асуудал ноцтой хэвээр байгаа бөгөөд 2020 онд Экологийн цагдаагийн алба байгуулагдсанаас хойш эдгээр гэмт хэрэг буурсан үзүүлэлттэй байна. 2023 онд нийт бүртгэгдсэн авлигын 569 хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилж үзэхэд 423 гэмт хэрэг (67.6 хувь) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглах, 99 (15.8 хувь) нь хээл хахууль авах гэмт хэрэг, 53 (8.5 хувь) нь хахууль өгөх гэмт хэрэг, 24 (3.8%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 19 (3.0%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан

⁸ Үндэсний статистикийн хороо


⁹ Мөн адил.

¹⁰ <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>

¹¹ Үндэсний статистикийн хороо

¹² Үндэсний статистикийн хороо

ашиглах гэмт хэрэг, 8 (1.3%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргүүд байна.¹³



Монгол Улсад 2022 оноос Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай шинэ хууль хэрэгжиж эхэлсэн. Монгол Улс 2006 оны 1-р сарын 11-ний өдөр Авлигын эсрэг НҮБ-ын конвенци¹⁴-д нэгдсэн. Улмаар Монгол Улс 2023-2030 онд хэрэгжүүлэх Авлигатай тэмцэх үндэсний шинэ стратеги боловсруулсан. Авлига нь Монгол Улсын төрийн байгууллагуудын хувьд томоохон сорилт болж байгаа төдийгүй улс нийгмээрээ зэмлэн буруушааж байна. Монгол Улсын Засгийн газар авлигатай тэмцэх хүчин чармайлтаа эрчимжүүлэн бэхжүүлэх, төрийн үйлчилгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, тэр дундаа Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх чиглэлээр мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргаж байна. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,

Авлигын эсрэг хуулиудыг үндэс болгож Монгол Улсын хөгжлийн дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хугацаа, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, олон нийтийн санал, дүгнэлттэй уялдуулан арван зорилго, 45 зорилт, 225 арга хэмжээ бүхий “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр-Авлигатай тэмцэх үндэсний стратеги (2023-2030)”-ийг боловсруулсан. Төрийн үйлчилгээг цахимжуулж, иргэдэд хүртээмжтэй, ил тод болгох зорилгоор Монгол Улс 2020 оноос e-Mongolia платформ¹⁵-ыг нэвтрүүлсэн. Түүнчлэн Монгол Улс саяхан “open.audit.mn” хэмээх аудитын цахим платформыг ажиллуулж эхэлсэн нь төрийн байгууллагуудын талаарх аудитын баримт мэдээлэлтэй олон нийт, иргэд, хэвлэл мэдээллийн байгууллагууд танилцах боломж нээгдэж ил тод байдлыг бэхжүүлж байна.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тогтолцоонд олон улсын хамтын ажиллагаа, эд хөрөнгө хураан авах эрх зүйн зохицуулалт дутмаг байна. Ялангуяа, олон улсын хамтын ажиллагаа, эд хөрөнгө хураан авах хүсэлт гаргах эрх зүйн болоод хэргийн удирдлагын тогтолцоо бүрдээгүй байна.

Үүнээс шалтгаалан эрүүгийн хэргийн асуудлаар бусад улс орнуудтай харилцан хамтран ажиллах хүсэлт хойшлогдох, амжилтгүй болох, тоо мэдээлэл хангалтгүй байх зэрэг нөхцөл бий болж байна. Монгол Улсын Ерөнхий прокурорын газар нь 2023 оны 6-р сард Зүүн Өмнөд Азийн хуулийн байгууллагуудын сүлжээ байгууллага (SEAJust)-ын гишүүн болсон.¹⁶ Энэхүү SEAJust сүлжээ байгууллага нь НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (МБГХТА/ UNODC)-ны дэмжлэгтэй хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааны сүлжээ бөгөөд гишүүн улс орнуудын эрх барих төв байгууллагуудын хооронд шууд харилцаа холбоо тогтоож эрүүгийн хэргийн асуудлаар харилцан эрх зүйн туслалцаа үзүүлэх албан бус платформ юм.

¹³ Үндэсний статистикийн хороо

¹⁴ <https://www.unodc.org/unodc/en/treaties/CAC/>

¹⁵ <https://e-mongolia.mn/home>

¹⁶ <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/SEAJust/index.html>

1.4 Дэлхий дахинд өрнөж буй үйл явц, Монгол Улсад үзүүлэх нөлөө

Цар тахлаас үүдэлтэй хямрал, геополитикийн ээдрээтэй байдал, эрчим хүчний үнэ, инфляцийн түвшний өсөлт зэргээс улбаалсан дэлхийн эдийн засгийн удаашрал Монгол Улсад нөлөөлсөөр байна. Монгол Улсын хамгийн том худалдааны түнш болох БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд гарч буй өөрчлөлт борлуулалт, хөрөнгө оруулалт, дотоодын эрэлт буурч, үнийн зохицуулалт хийгдэж байгаа зэргээр илэрч байна. Энэ нь Монголын экспортын эрэлтэд нөлөөлөх нь гарцаагүй.¹⁷ Азийн хөгжлийн банкны (АХБ) Бүс нутгийн эдийн засгийн төлөв байдал¹⁸ тайланд БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн хямрал нь олон улсын болоод бүс нутгийн түншүүдэд дунд зэргийн нөлөө үзүүлэхээр байгааг тэмдэглэжээ. Харин 2023 онд Монгол Улсын эдийн засгийг мэдэгдэхүйц өсгөх хөдөлгөгч хүч болсон БНХАУ-тай хийж буй худалдаанаас Монгол Улсын эдийн засгийн өсөлт ихээхэн хамааралтай байгаа учир тус улсад учрах нөлөө өндөр байх төлөвтэй байна.

Энэ онд зохион байгуулагдсан Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх асуудлаарх Талуудын 27, 28 дугаар Бага хурал зэрэг олон улсын цөөнгүй чуулга уулзалтад Монгол Улсын Засгийн газар оролцож хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэхийг дэмжиж дараалсан мэдэгдэл хийсэн боловч түүнийгээ хэрэгжүүлэх талаар бодитой ахиц дэвшил гаргаагүй төдийгүй хөгжлийн хөтөлбөртөө ч тодорхой тусгаагүй байна. Бодит байдал дээрээ Монгол Улс хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэхэд чиглэсэн үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөө ч байхгүй байна. Иймээс хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэх асуудлаар Монгол Улсын Засгийн газар дорвитой алхам хийхэд түлхэц болох арга хэмжээг Монгол Улс дахь НҮБ-ын зүгээс хэрэгжүүлэх хөтөлбөрүүдэд тусгах шаардлагатай байна.

Хүлэмжийн хийн ялгарал, шингээлтийн зөрүүг тэглэх шилжилт, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөллийг сааруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлснээр эдийн засгийн боломж, өсөлтийг орон нутгийн түвшинд нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Монгол Улс нь далайд гарцгүй хөгжиж буй орнуудын нэг бөгөөд эдийн засгийн үйл ажиллагаандаа газар зүйн ихээхэн бэрхшээлтэй тулгарч байдаг. Дэлхийн банкны тээвэр Ложистикийн гүйцэтгэлийн индекс (ЛГИ)-ийн 2023 оны¹⁹ тайланд Монгол Улс 2.5 оноотойгоор 97-д эрэмбэлэгдсэн бөгөөд дэд бүтэц, ложистикийн өрсөлдөх чадвар, чанарын хувьд Монгол Улсын гүйцэтгэл сайнгүй байна. Далайд гарцгүй хөгжиж буй орнууд (ДГХБО)-ад тулгарч буй өвөрмөц сорилтуудыг шийдвэрлэх зорилгоор НҮБ 2014 онд Венийн Үйл ажиллагааны хөтөлбөр (VPOA)²⁰ хэмээх арван жилийн төлөвлөгөөг баталсан билээ. НҮБ-ын гишүүн орнууд 2024 онд болох Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын асуудлаарх НҮБ-ын 3-р Бага хурал²¹ -аар ДГХБО-ын шинэ арван жилийн төлөвлөгөөг батлахаар бэлтгэж байна. Монгол Улс газар зүйн байршлын сул талаа тооцон манлайлал үзүүлж чанарын өндөр түвшинд судалгаа, нөлөөлөл сурталчилгаа хийж далайд гарцгүй хөгжиж буй орнуудын чадавхийг сайжруулах зорилго бүхий Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын судалгааны төв (ДГХБО-ОУСТ/ITT-LLDCs)²² -ийг байгуулсан. Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын асуудлаарх НҮБ-ын 3-р Бага хурлыг 2024 онд зохион байгуулж ДГХБО-ын шинэ арван жилийн төлөвлөгөөг батлах үйл явцад ДГХБО-ОУСТ төв манлайлж оролцоход Монгол Улсын Засгийн газрын зүгээс бодитой хүчин чармайлт гаргах шаардлагатай. Үүнд чиглэсэн дэмжлэгийг Монгол Улс дахь НҮБ Хамтарсан Ажлын Төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлэх нь чухал байна.

¹⁷ <https://www.adb.org/sites/default/files/publication/908126/asian-development-outlook-september-2023.pdf>

¹⁸ АХБ, Азийн хөгжлийн төлөв, 2023 оны 9-р сар

¹⁹ <https://lpi.worldbank.org/international/global>

²⁰ https://www.un.org/ohrrls/sites/www.un.org.ohrrls/files/vienna_programme_of_action.pdf

²¹ <https://www.un.org/en/landlocked/about-third-un-conference-ldcs>

²² <https://land-locked.org/>

1.5 Цахим хөгжил, хөдөө аж ахуй, бусад ахиц дэвшил

Монгол Улсын Засгийн газар төрийн үйлчилгээг цахимжуулах ажлаа 2023 онд амжилттай үргэлжлүүлэн хөгжүүлж байна. Төрийн үйлчилгээний үйл явцыг тодорхой болгож, илүү олон үйлчилгээг нэмж сайжруулсан e-Mongolia 3.023 цахим платформыг нэвтрүүлснээр төрийн үйлчилгээг нийт иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс чөлөөтэй, хүртээмжтэй авах боломж бүрдсэн. Мөн Монгол Улсын Засгийн газар аж ахуйн нэгжийн бүртгэл, тусгай зөвшөөрөл олгох зэрэг аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн төрийн үйлчилгээ үзүүлэх e-business²⁴ цахим платформыг нэвтрүүлж эхэлсэн.

НҮБ-ын Худалдаа, хөгжлийн Бага хурлын (НҮБ-ын ХХБХ) албаны дэмжлэгтэйгээр Монгол Улсын Засгийн газар 2023 оны 5-р сард цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ²⁵-г амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү үнэлгээний хүрээнд цахим экосистемийг нарийвчлан оношилж, хүртээмжтэй, тогтвортой дижитал эдийн засагт шилжих шилжилтийг хурдасгах бодлогын шинэчлэлийн хувилбарыг тодорхойлох зэргээр цахим худалдааг хөгжүүлэхэд тулгарч буй гол саад бэрхшээл, боломжуудыг шинжилсэн. Тус үнэлгээний гол дүгнэлтээс дурьдвал:



Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны (ХХААХҮЯ) мэдээгээр Монгол Улс 2023 онд улаан буудай, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн таримлын ургацыг сүүлийн 10 жилд хамгийн өндөр хэмжээнд хураан авчээ. Нийт хураасан улаанбуудай 32 мянган тонноор (8%), хүнсний ногоо 32 мянган тонноор (23%), малын тэжээл 82 мянган тонноор (45%) тус тус нэмэгджээ. Ургац хураалт ийнхүү нэмэгдсэнээр Монгол Улс улаан буудай, төмсний хэрэгцээгээ 100 хувь, хүнсний ногооны хэрэгцээний 85 хувийг дотоодын ургацаас хангах боломж бүрджээ. Дотоодын хүнсний ногооны үйлдвэрлэл

2022 онтой харьцуулахад бараг 40 хувиар өссөн нь хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд тариалан эрхлэгчид, хүнсний ногоо тариалагчдад санхүүгийн таатай орчин бүрдүүлсэнтэй холбоотой. Бордоо болон техник, тоног төхөөрөмжийн худалдан авалтад Засгийн газраас 50 хувийн татаас олгож, банкны эргэлтийн хөрөнгийн зээлийн хүүг бууруулж дэмжлэг үзүүлж байна.

Дотоодын сүүний үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Засгийн газраас мал аж ахуй эрхлэгчид, малчдын нийлүүлсэн сүүнд олгох татаасын шинэ

²³ <https://e-mongolia.mn/Home>

²⁴ <https://e-business.mn/home>

²⁵ <https://unctad.org/publication/mongolia-etradereadiness-assessment>



НҮБ-ын Хүүхдийн сан нь Мобиком компанитай хамтран хөдөө орон нутгийн сурагчдын цахим боловсрол эзэмших боломжийг дээшлүүлж байна. © НҮБ-ын Хүүхдийн сан

хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Малчид, мал аж ахуй эрхлэгчдээс боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлсэн сүүний литр тутамд 500 төгрөгийн татаас олгож байна. Энэхүү шинэ схемийг нэвтрүүлснээр одоогоор 50 хувиас доош ашиглалттай байгаа сүү боловсруулах үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэх болно.

Монгол Улс ноолуур экспортлоход мөрдөх техникийн зохицуулалтыг шинээр хэрэгжүүлэх гэж байна. Түүхий ноолуур экспортлохыг хориглож, зөвхөн самнасан ноолуур экспортлох тухай Засгийн газрын хүсэлтийг УИХ-ын чуулганаар хэлэлцэж эцэслэн баталсан. Ноолуур самнах үйлдвэрүүдийн хүчин чадал хязгаарлагдмал, түүхий ноолуурын үнэ буурах эрсдэлтэй гэсэн маргаанаас үүдэн хэдэн жил гацаанд ороод байсан энэхүү шинэ журмыг ХХААХҮЯ, Монголын ноос ноолуур боловсруулах үйлдвэрүүдийн холбоо хамтран УИХ-д удаа дараа өргөн мэдүүлж байжээ. ХХААХҮЯ болон УИХ-аас томилогдсон УИХ-ын гишүүдээс бүрдсэн ажлын хэсгийн хамтарсан үнэлгээ хийж дотоодын ноолуур самнах үйлдвэрүүдийн нийт хүчин чадал 17 мянган тоннд хүрсэн байгаа нь үндэсний хэмжээний ноолуур үйлдвэрлэлээс давсан хүчин чадал байна гэж дүгнэжээ. Дотоодын самнах үйлдвэрүүдийн суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглахыг дэмжих нь Монгол Улсын эдийн засгийн сэргэлтийн шинэ бодлогод ноолуур экспортлох

техникийн зохицуулалтыг шинээр хэрэгжүүлэхээр тусгагдсан нэн тэргүүний зорилтын нэг юм.

Кадастрын зураглал ба кадастрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын зураглал, газрын бүртгэлийн тухай хууль, Газрын эрх олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурал хэлэлцэж баталлаа. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь Монгол Улсын газар зохион байгуулалтын бодлогын нэгдмэл байдлыг хангах, төрийн байгууллагуудын давхардсан чиг үүргийг багасгах, үйлчилгээг сайжруулах зорилготой юм. Хуулиудын шинэчилсэн найруулгыг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс Барилга, хот байгуулалт, тээврийн яамны харьяа Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрыг Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлж, гүйцэтгэлд хяналт тавих, газар зохион байгуулалтын асуудлаар салбарын яам, аймгийн ЗДТГ-ын ажлын уялдаа холбоог зохицуулах тодорхой эрх мэдэлтэй болгосон.

НҮБ-ын ХХААБ-ын техникийн туслалцаатайгаар ХХААХҮЯ Хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий Ногоон, өрсөлдөх чадвартай, экспортод чиглэсэн хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийг 2023-2030 онд хөгжүүлэх стратегийг боловсруулсан.

2 | БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, БАЙГАЛЬ ОРЧИН



2.1

Биологийн олон янз байдлыг хамгаалах:

Ой, тусгай хамгаалалттай газар нутаг, цөлжилт



Монгол Улс амьдрах орчин, биологийн олон янз байдлыг хамгаалах зорилгоор улсын тусгай хамгаалалттай газар нутгаа өргөтгөж байна. © НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

Монгол Улсын нийт газар нутгийн 7.7 хувь нь ойгоор бүрхэгдсэн байдаг. Сүүлийн үед дэлхийн дулаарал, хуурайшилтаас шалтгаалж ой хээрийн түймрийн давтамж нэмэгдэж, хорт шавж олшрох болсон. Энэ нь Монгол орны ой доройтож хомсдох гол хүчин зүйл болж байна.²⁶ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийн экологийн тэнцвэрт байдлыг хамгаалж, сайжруулах зорилготой “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг 2021 онд эхлүүлсэн. Улсын хэмжээнд 2021-2022 онд 39 зүйлийн мод, сөөгний 12 тонн үрийн нөөц бүрдүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 4.5 дахин нэмэгджээ. Үүний зэрэгцээ улсын хэмжээнд 10 сая гаруй мод тарьж, арчилж, хамгаалж байна. Мөн мод үржүүлгийн 306 газар 46 сая тарьц, суулгац нөөцтэй болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад дөрөв дахин нэмэгдсэн байна.²⁷

2023 оны 10-р сарын байдлаар Тусгай хамгаалалттай газар нутгийн нэгдсэн санд нийт тусгай хамгаалалттай 109 газар бүртгэгдсэн бөгөөд тусгай хамгаалалтад аваагүй ч газар зүйн хувьд үр дүнтэй байгаль хамгаалах арга хэмжээ (OECMs) авч байгаа газар нутаг одоогоор бүртгэгдээгүй (0) байна. Хуурай болон гүний усны хамгаалалттай газар нутгийн хамрах хүрээ 19.8 хувь (310,016 км²) байна. Нийт 32 тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын үнэлгээг хийж Дэлхийн Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигт байдлын мэдээллийн санд (GD-PAME) тайлагнажээ. Тус улсын хуурай газрын 13.31 хувь (208,433 км²) нь менежментийн үр ашигт байдлын үнэлгээ хийгдсэн тусгай хамгаалалттай газар нутаг байна.²⁸ Монгол Улс үндэсний тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээгээ аймаг (нийслэл), сум (дүүрэг)-ийн захиргаанаас тогтоосон

²⁶ Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2023: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт <https://hlpf.un.org/sites/default/files/vnrs/2023/VNR%202023%20Mongolia%20Report.pdf>

²⁷ Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2023: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт <https://hlpf.un.org/sites/default/files/vnrs/2023/VNR%202023%20Mongolia%20Report.pdf>

²⁸ UNEP-WCMC (2023). Protected Area Profile for Mongolia from the World Database on Protected Areas, October 2023. Available at: www.protectedplanet.net

орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгаар нэмэгдүүлэн өргөжүүлж байна. Амьдрах орчны доройтол, бэлчээрийн даац хэтрэлт, уул уурхайн олборлолт, мод бэлтгэл, түймэр, дэд бүтцийн хөгжил, ан агнуур, уур амьсгалын өөрчлөлт дагасан асуудлууд нь тусгай хамгаалалттай газар нутгийн болон бусад газар нутгийн биологийн олон янз байдлыг хамгаалахад сорилт бэрхшээл учруулж байна. Эдийн засгийг төрөлжүүлэх нэг гол тулгуур бол аялал жуулчлалыг хөгжүүлэх хэмээн үзэж Монгол Улсын Засгийн газар өв соёлд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарал хандуулж эхэлсэн.²⁹

Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөв байдлын шинжилгээг нийтэлснээс хойш НҮБ-ын БШУСБ-ын Шим мандлын нөөц газрын дэлхийн сүлжээнд газар нутгаа бүртгүүлэх асуудлаар ахиц дэвшил гарсан. Онон-Балжийн ай сав нутаг нь Сибирийн ой тайгын өмнөд сэжүүрт, Дагуурын хээр тал, Онон, Балж голын сав газрыг бүрхэж оршдог өвөрмөц тогтоцтой газар нутаг юм. Энэхүү Онон-Балжийн байгалийн цогцолборт газрыг 2023 оны 6-р сарын 14-ний өдөр НҮБ-ын БШУСБ-ын Шим мандлын нөөц газрын дэлхийн сүлжээнд бүртгэн баталгаажуулсан. Онон, Балжийн сав газар нь устай намгархаг газар бөгөөд усны шувууд олноор цуглардаг чухал цэг төдийгүй Чингис хаантай холбоотой түүхэн дурсгалт газруудын арвин их нөөцтэй. Энэ нь соёлын аялал жуулчлалыг татахаас гадна байгаль орчинд ээлтэй, олон нийтэд түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжийг нээсэн.³⁰

Монгол Улсын цөлжилтийн судалгаагаар 2020 оны байдлаар нийт нутаг дэвсгэрийн 76.9 хувь буюу 120.3 сая га газар нутаг доройтолд орсны 4.7 хувь нь туйлын доройтолд, 18.6 хувь нь хүчтэй доройтолд нэрвэгдсэн байна. Дорноговь, Дундговь, Өмнөговь, Говь-Сүмбэр, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгийн нийт нутаг дэвсгэрийн 50-70 хувь нь цөлжилт, газрын доройтолд нэрвэгдсэн.³¹

Газрын доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд ихээхэн хүчин чармайлт шаардагдана. Цөлжилтөд хүргэж буй байгалийн хүчин зүйл бол уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн улам даамжирч буй ган, хуурайшилт юм. Хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гол хүчин зүйлүүд нь мал сүргийн тоо толгой хэт нэмэгдэх, бэлчээрийг зүй бусаар ашиглах явдал юм.³²

НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Талуудын 15 дугаар Бага хурлын 34 дүгээр шийдвэрийн дагуу Монгол Улс НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцийн Талуудын 17 дугаар Бага хурал (COP-17)-ыг 2026 онд эх орондоо зохион байгуулна.³³

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2022 оны 7-р сарын 28-ны өдрийн чуулганаар хүн бүр цэвэр, эрүүл, тогтвортой орчинд амьдрах эрхтэй хэмээн тунхагласан тогтоолыг³⁴ баталж, энэхүү зарчмыг чанд баримтлахын тулд дэлхий нийтээр илүү их хүчин чармайлт гаргахыг уриалсан.³⁵ Монгол Улс ч мөн үндэснийхээ хэмжээнд хүний амьдрах орчны эрхийг хүндэтгэн хамгаалахад чиглэсэн хүчин чармайлт гаргах түүхэн тогтоолыг батлахыг дэмжиж нэгдсэн. Эрүүл мэндийн төлөөх байгаль орчин (N4H) санаачилга нь 'Нэг эрүүл мэндийн төлөө' хөдөлгөөнийг улс үндэстнүүдэд өрнүүлэх дэлхийн санаачилга юм. Эрүүл мэндийн төлөөх байгаль орчин (ЭМТБО/N4H) санаачилга нь хүн, амьтан, экосистемийн эрүүл мэнд харилцан хамааралтайд анхаарал хандуулж бүх талууд хамтран Нэг эрүүл мэндийн төлөөх байгаль орчны асуудлыг шийдвэрлэх замаар болзошгүй цар тахлын эрсдэлийг бууруулах зорилготой.³⁶

Монгол Улс Эрүүл мэндийн төлөөх байгаль орчин (ЭМТБО/N4H) санаачилгад 2022 оны 12-р сард нэгдсэн.³⁷

²⁹ <https://www.adb.org/sites/default/files/publication/400816/mongolia-environment-sector-fact-sheet.pdf>

³⁰ <https://www.unesco.org/en/articles/unesco-designates-11-new-biosphere-reserves-0>

³¹ Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2023: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт <https://hlpf.un.org/sites/default/files/vnrs/2023/VNR%202023%20Mongolia%20Report.pdf>

³² Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл 2023: Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилт <https://hlpf.un.org/sites/default/files/vnrs/2023/VNR%202023%20Mongolia%20Report.pdf>

³³ https://www.unccd.int/sites/default/files/2022-10/34_cop15.pdf

³⁴ <https://digitallibrary.un.org/record/3983329?ln=en>

³⁵ <https://press.un.org/en/2022/ga12437.doc.htm>

³⁶ <https://nature4health.org/>

³⁷ <https://montsame.mn/en/read/309972>

2020 оноос хойшхи Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээг (ДБОЯБХ/GBF) 2022 оны 12-р сард Биологийн олон янз байдлын тухай конвенцийн Талуудын 15 дугаар Бага хурлаар баталсан. Энэхүү Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ (ДБОЯБХ) батлагдсанаар биологийн олон янз байдлын асуудлыг уур амьсгалын өөрчлөлттэй эн зэрэгцүүлэн дэлхийн хамтын нийгэмлэгийн

өмнө тулгарч байгаа байгаль орчны нэн тэргүүний хос зорилт болгосон. Дээрх шинээр батлагдсан ДБОЯБХ болон Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт (ҮТХН)-той уялдуулан Монгол Улс Биологийн олон янз байдлын үндэсний стратеги, үйл ажиллагааны төлөвлөгөө болон хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдээ 2024 оны эхээр шинэчлэн боловсруулах төлөвлөгөөтэй байна.

2.2 Бохирдол

Нэг хүнд ногдох хуванцар хог хаягдлын хэмжээгээр дэлхийд эхний 10-т Монгол Улс багтаж байна. Дахин боловсруулсан хуванцар бүтээгдэхүүний зах зээлийн шинэхэн судалгаагаар нэг хүн жилд дунджаар 137.58 кг хуванцар хог хаягдал ялгаруулж байна.³⁸ Мөн Монгол Улс хуванцарыг багасгах, нэг удаагийн хуванцарыг хориглох талаар заавал биелүүлэх тодорхой бодлого, зорилтуудыг хэрэгжүүлэхээр тэмцэл өрнүүлж байна. Бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаалах, үйлчилгээнд хэрэглэх, үйлдвэрлэх, импортлохыг хориглох шийдвэрийг Монгол Улсын Засгийн газар 2018 онд гаргасан хэдий ч хэрэглээ өндөр хэвээр байна.³⁹

Монгол Улсын агаарын бохирдлын түвшин зонхилон өвөл, хаврын улиралд, ялангуяа Улаанбаатар хот болон аймгийн төвүүдэд ихээр нэмэгддэг. Өвлийн улиралд ахуйн хэрэглээнээс гадна халаалтын зориулалтаар эрчим хүчний хэрэглээ өсөхийн

хэрээр агаарын бохирдол ч улам бүр нэмэгдэж байна. Гэр хорооллынхон, байр сууц нийлээд жил бүр 200 гаруй мянган шоо метр түлш хэрэглэж байна. Өвлийн улиралд түдгэлзүүлсэн нарийн ширхэглэгт тоосонцорын ялгарал (SPM) оргилдоо хүрч байна.⁴⁰

Монгол орны агаарын бохирдлын гол эх үүсвэр нь гэр хорооллын айл өрхүүд ахуйн болоод халаалтын зорилгоор нүүрс, мод түлж байгаа явдал юм. Мөн зам тээврийн хөдөлгөөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үлдэгдэл, биомассыг ил задгай шатаах, тоосгоны үйлдвэр зэрэг бусад эх үүсвэрээс ялгарч буй агаар бохирдуулагч нь тус улсын агаарын чанарт нөлөөлж байна. Нийслэлийн агаарын бохирдлын 80 орчим хувь, ширхэглэгт тоосонцорын ялгаруулалтын 80 орчим хувь нь гэр хороолол, 10 орчим хувь нь авто замын хөдөлгөөн, 6 хувь нь цахилгаан дулааны станц, 4 хувь нь ил задгай хатуу хог хаягдал, хөрс болон бусад зүйлсийн шаталт зэргээс үүдэлтэй байна.⁴¹



Улаанбаатар хотын өвлийн улиралд утаа, агаарын бохирдол нийгмийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

© НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

³⁸ <https://mongolia.charita.cz/media/press-releases/mongolia-is-in-top-ten-countries-that-produces-the-most-plastic-waste-per-person-says-market-researcher/>

³⁹ <http://www.mongolianbusinessdatabase.com/base/newsdetials?id=29628>

⁴⁰ https://www.eanet.asia/wp-content/uploads/2020/04/7-Mongolia_Factsheet_compressed.pdf

⁴¹ https://www.eanet.asia/wp-content/uploads/2020/04/7-Mongolia_Factsheet_compressed.pdf

2.3 Уур амьсгалын өөрчлөлт

Монгол Улс нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж буй улс орнуудын нэг юм. Хэдийгээр Монгол Улс нь дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтын дөнгөж 0.1 хувийг бүрдүүлж байгаа ч нэг хүнд ногдох болон ДНБ-ий нэг нэгжид ногдох хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээгээр дэлхийн дунджаас өндөр байна.⁴²


Монгол Улс 2030 он гэхэд дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулахад оруулах Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтоо (ҮТХН) ердийн нөхцөлтэй харьцуулахад 27.2 хувь (нөхцөлт) буюу 22.7 хувь (нөхцөлт бус) бууруулахаар ахиулан шинэчилж тодорхойлсон. Түүнчлэн зорилтоо ойн аж ахуйн нэмэлт бүрэлдэхүүн хэсгийг оруулсан бөгөөд энэ нь 2030 он гэхэд нийт хүлэмжийн хийн ялгарлыг 44.9 хувь хүртэл бууруулахад хувь нэмэр оруулна. Мөн шинэчилсэн ҮТХН-ийн хамрах хүрээнд хөдөө аж ахуй, хог хаягдал, аж үйлдвэрийн зарим салбарыг оруулж өргөжүүлсэн.⁴³ Монгол Улс ҮТХН-ийн зорилтоо биелүүлэхэд 11.5 тэрбум ам.доллар шаардагдах тооцоо бий. Энэхүү санхүүжилтийг татан төвлөрүүлэхийн тулд Монгол Улс жил бүр ДНБ-ийхээ нэг хувийг уур амьсгалын өөрчлөлт, цөлжилттэй тэмцэхэд зарцуулахаар шийдвэрлэсэн.⁴⁴

Монгол Улс 2021 оны Нотр Дамын Дэлхийн дасан зохицох санаачилга (НД-ДДЗС/ND-GAIN)-ын индексээр 54.2 оноо авч 60-д эрэмбэлэгдсэн. НД-ДДЗС-ын индекс нь уур амьсгалын өөрчлөлт болон дэлхий дахинаа тулгарч буй бусад сорилтод улс орнуудын өртөмтгий байдал, аливаа цочролыг тэсвэрлэх чадварыг сайжруулахад бэлэн байгаа эсэхийг нь тодорхойлон нэгдсэн дүгнэлт гаргадаг. Энэ нь дэлхий дахинаа тулгарч буй сорилтод илүү үр дүнтэй хариу өгөхийн тулд тэргүүлэх зорилтоо хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлэх

талаар улс орнуудын засгийн газар, бизнес эрхлэгчид болон нийгмийн төлөөлөлд туслах зорилготой.⁴⁵

Монгол Улсын нүүрсхүчлийн хийн эрчим дэлхийн дунджаас бараг 15 дахин өндөр, нэг хүнд ногдох хүлэмжийн хийн ялгаруулалт 21 тонн байгаа нь дэлхийд дээгүүрт ороход хүргэж байна.⁴⁶ Монголын нүүрстөрөгчийн ул мөрийг бий болгоход хамгийн их хувь нэмэр оруулж буй хүчин зүйл бол газар ашиглалтын өөрчлөлт юм. Тус улсын нийт ялгаруулж буй хүлэмжийн хийн 44 хувь нь газар ашиглалтаас эх авч байна. Энэ нь хүрээгээ тасралтгүй аажмаар тэлж буй цөлжилтийн аюулд өртөж ой мод устгах, мод бутыг гэмтээж байгаа хортон шавж өсч үржиж байгаа зэргээр илэрч байна.⁴⁷

Монгол Улс нь газарзүйн байршил, уур амьсгалын нөхцөл байдлаас шалтгаалан 2600 гигаватт⁴⁸ орчим сэргээгдэх эрчим хүчний арвин их нөөцтэй. Энэ нь Монгол Улс сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэлээ нэмэгдүүлж, бүс нутгийн эрчим хүчний хангамжийн сүлжээнд хувь нэмэр оруулах боломжтойг харуулж байна. Монгол Улсын эрчим хүчний системийн нийт суурилагдсан хүчин чадалд сэргээгдэх эрчим хүчний эзлэх хувь 18.2 байгаа бөгөөд үүнийг 2030 он гэхэд 30 хувьд хүргэх зорилт тавин ажиллаж



байна. Монгол Улсын малчин өрхийн 75 хувь нь сэргээгдэх эрчим хүч хэрэглэж байна. Монгол орон сүүлийн 70 жилийн дэлхийн дунджаас бараг гурав дахин өндөр эрчмээр дулаарч байгаагийн зэрэгцээ уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эрсдэлтэй улс болж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн

⁴² <https://montsame.mn/en/read/307646>

⁴³ <https://climatepromise.undp.org/what-we-do/where-we-work/mongolia>

⁴⁴ <https://montsame.mn/en/read/321190>

⁴⁵ <https://gain-new.crc.nd.edu/ranking>

⁴⁶ <https://climatepromise.undp.org/what-we-do/where-we-work/mongolia#:~:text=Mongolia%20enhanced%20its%20mitigation%20ambition,compared%20to%20business%20as%20usual>

⁴⁷ <https://climatepromise.undp.org/what-we-do/where-we-work/mongolia#:~:text=Mongolia%20enhanced%20its%20mitigation%20ambition,compared%20to%20business%20as%20usual>

⁴⁸ <https://montsame.mn/en/read/307646#:~:text=Mongolia%20has%20huge%20renewable%20energy,energy%20supply%20of%20the%20region>

нөлөөгөөр Монгол Улсад зудын давтамж, хүндрэл нэмэгдэж байгаа нь малчдын амьжиргаа, хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, албадан нүүлгэн шилжүүлэх хөдөлгөөнийг үүсгэж, айл өрхийн эмзэг байдлыг улам бүр хурцатгаж байна (2.4-р хэсгийг үзнэ үү).

Метан хийн ялгарлыг бууруулах олон улсын санаачилгад дэмжлэг үзүүлэх, энэ чиглэлээрх дэлхий нийтийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой Дэлхийн Метаны амлалтад Монгол Улс нэгдсэн. Эрчим хүч, хөдөө аж ахуй, хог хаягдлын менежментээс шалтгаалсан метан хийн ялгарлыг хурдацтай бууруулах нь дэлхийн дулаарлыг 1.5°C хэмээс доош хязгаарлах зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулахын зэрэгцээ нийгмийн эрүүл мэнд, хөдөө аж ахуйн бүтээмжийг сайжруулах зэрэгт давхар үр нөлөөтэй.⁴⁹

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх үйл ажиллагаа, байгаль орчныг хамгаалах нөлөөлөл сурталчилгааны ажилд залуучууд чухал үүрэг гүйцэтгэнэ. Байгаль орчны боловсрол олгох хөтөлбөрийг сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгаж, байгаль орчны бодлого боловсруулах үйл явцад залуучуудыг татан оролцуулж Монгол Улсын өмнө тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх сорилт бэрхшээлийг даван туулах тогтвортой, шинэлэг шийдэл олоход тэдний хүчийг ашиглах нь чухал байна.

Монгол Улс (болон НҮБ-ын гишүүн нийт улс орон) Уур амьсгалын асуудлаарх суурь конвенцийн Талуудын 29 дүгээр Бага хурлаас гаргасан уур амьсгалын санхүүжилтийн талаарх шийдвэрийг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа улам сайжруулах нь чухал байна. Үүнд:

- Бодлогын удирдамж, урамшууллын механизм, зохицуулалтыг бэхжүүлж хүлэмжийн хий бага ялгаруулдаг, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийг бий болгоход шаардагдах хэмжээний хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Засгийн газар, төв банкууд, арилжааны банкууд, институтцийн хөрөнгө оруулагчид болон бусад санхүүгийн оролцогчдын уур амьсгалтай холбоотой санхүүгийн эрсдэлийг илүү сайн судалж, үр дүнтэй удирдах;
- Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх татварын болоод санхүүгийн шинэ болон шинэлэг эх үүсвэрийг бий болгох ажлыг шуурхайлах, улмаар үр ашиг муутай урамшууллын механизмын цар хүрээг хумих шаардлагатай;
- Хөгжиж буй улс орны хэрэгцээ, тэргүүлэх чиглэлд нийцсэн уур амьсгалын санхүүжилтийг дайчлах улс орны стратегийг дэмжих зэрэгт анхаарал хандуулах нь чухал.



Байгаль орчны хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд залуусын манлайлал чухал. © НҮБ-ын СЗГ

⁴⁹ <https://www.globalmethanepledge.org/#about>

2.4 Гамшгийн эрсдэл

Монгол Улсад тохиож буй аюулт үзэгдэл, ослын тоо буурсан хэдий ч (Зураг 6) уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үзэгдлүүд 2.9 дахин нэмэгджээ.

Монгол Улсын хэмжээнд 2015-2021 онд тохиосон гамшиг, аюултай үзэгдэл, ослын улмаас (КОВИД-19 цар тахлыг эс тооцвол) нийт 3501 хүн амь нас эрсэдсэн байна.

Зураг 6. Монгол Улсад тохиосон аюулт үзэгдэл, ослын тоо (жилээр)



Эх сурвалж: Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн Монгол Улсын дунд хугацааны тайлан


Монголд байнга тохиолддог гамшгийн нэг төрөл бол зуд юм. Зуншлага тааруу ган гачиг болох тохиолдолд бэлчээр хомсдож, хадлан тариалан хангалттай авч чадахгүй өвлийн улиралтай золгож их хэмжээний цас орж, салхи шуурга тавин, агаарын температур хэвийн хэмжээнээс доош орж хүйтрэн байгалийн гамшгийн нөхцөлд хүрэх нь олонтаа тохиолдож байна. Сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсад 6 удаа зуд болжээ. 2023/2024 оны өвөл тус улсын нутаг дэвсгэрийн 90 хувь нь зудын өндөр эрсдэлтэй тулгарч, 190 мянган малчин өрхийн амьжиргаанд хүнд цохилт болсон. Улсын нийт нутгийн 70 гаруй хувь нь зудтай, зуд болох эрсдэл өндөртэй байна. Тэдгээрийн 50 хувь нь зудад нэрвэгдсэн, 20 хувь нь зуд болох өндөр эрсдэлтэй нөхцөлд байна. Малчин айл өрхүүдэд зудын уршиг нөлөө маш хүндээр тусч байна. Зудад малаа алдах өндөр эрсдэлтэй малчин айл өрхүүдийн амьжиргаа доройтох, амьдрахын эрхээр хөдөөнөөс хот руу чиглэсэн дотоод шилжилт хөдөлгөөнд орох зэрэг хөгжлийн олон асуудал үүсэх суурь шалтгаан болж байна. Монгол Улсын Засгийн газраас боловсруулсан ямар нэгэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ

аваагүй тохиолдолд учирч болзошгүй мал сүргийн хорогдлын тооцоог доорх Зураг 7-д үзүүлэв.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн аюултай үзэгдлүүд нь Монгол Улсын нийт салбарт гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үнэлгээг хийх шаардлагатайг илэрхийлж байна. Монгол Улсын Засгийн газрын хүсэлтийн дагуу НҮБ болон Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллага хамтран 2023 онд Гамшгийн эрсдэлийг бууруулах санаачилгын чадавх (ГЭБСЧ/CADRI)-ийг оношлох судалгаа хийсэн. Тус судалгаагаар гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой дараах урьдчилсан дүгнэлт гарсан. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газраас Гамшгаас урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг сайтар боловсруулан батлуулж төв, орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөлийг байгуулан хэрэгжүүлж байна. Улс, орон нутгийн засаг захиргааны нэгж бүр гамшгаас хамгаалах стратеги, гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй байна. Бүх түвшний төрийн албан

Зураг 7. Ямар нэгэн урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй тохиолдолд учирч болзошгүй мал сүргийн хорогдлын тооцоо



Эх сурвалж: Онцгой байдлын ерөнхий газраас гаргасан 2023/2024 оны зудын хохирол, болзошгүй хохирлын урьдчилсан мэдээ, 2023 оны 12-р сарын 20-ны өдрийн байдлаар.

хаагчид гамшгаас урьдчилан сэргийлэх талаарх хууль эрх зүйн болоод зохион байгуулалтын тогтолцоо, бодлогын удирдамж, дүрэм журмын талаар тодорхой мэдлэг мэдээлэлтэй байна. Гэхдээ эрсдэлийг бууруулах чиглэлээр салбарын яамд, газруудын хүлээх үүрэг хариуцлагын талаар зарим эргэлзээ, тодорхойгүй байдал ажиглагдаж байна. Түүнчлэн өнөөгийн хууль эрх зүйн болоод бодлогын хүрээнд нийгэм, эдийн засгийн эмзэг нөхцөлд байгаа хүн амын бүлгүүдэд хүргэх үйлчилгээ хязгаарлагдмал байна. Энэхүү эрсдэлийн үнэлгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, хүүхдүүд, эмзэг бүлгийн хүмүүсийн оролцоо хангалттай бус байсныг тэмдэглэх хэрэгтэй.

- Гамшгийн эрсдэлийг бууруулахад зориулж улсын төсвийн нэг (1) хувийг хуваарилах, гамшгаас хамгаалах, сэргээн босгох арга хэмжээнд зориулж аймгийн нөөц сангийн 30 хувийг хуваарилах гэх зэрэг гамшгийн эрсдэлийг бууруулах олон төрлийн санхүүжилтийн арга механизмыг Монгол Улсын Засгийн газар тодорхойлсон байна. Гэсэн хэдий ч салбарын яамд, газрууд гамшгийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагаатай холбоотой

чиг үүргээ биелүүлэхэд зориулж хангалттай төсөв бүрдүүлж чадахгүй байна. Мөн аймгууд улсын төсвийн нэг хувийг гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд бус харин гамшгийн эсрэг тэмцэх үйл ажиллагаанд зарцуулж байна.

- Монгол Улсад цаг уурын аюулт үзэгдэл (зуд, ган, хүчтэй салхи шуурга), геологи газар зүйн аюул (газар хөдлөлт), усны аюул (үер) зэргийг хянаж шинжлэх, ажиглах, үнэлгээ өгөх боломжтой систем, технологи байгаагийн зэрэгцээ аюулын шинжилгээ, газрын зураглалууд ч бий. Гэсэн хэдий ч эрсдэлийн мэдээллийн санг илүү сайн бүрдүүлж тодорхойлоход шаардагдах болзошгүй аюулын хяналт шинжилгээ, үнэлгээ, загварчлал хийх чадавхийг сайжруулах шаардлагатай байна. Мөн тус улс эрсдэлийг бууруулах шийдэл, технологийн судалгаа, хөгжилд илүү их хөрөнгө оруулах шаардлагатай.
- Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газраас төрийн албан хаагчдад зориулсан сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж байгаа боловч төрийн албан хаагчид болон хүн амын сэтгэхүйг эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чиглүүлж өөрчлөлт хийх шаардлага их байна.

3 | УЛС ТӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ



3.1 Бодлого, засаглал, институцийн өөрчлөлт

Монгол Улсын 2023 оны улс төрийн дүр төрх, нөхцөл байдлыг Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, сонгууль, улс төрийн намуудтай холбоотой хуулиудыг шинэчлэн баталсан, Хөгжлийн банк, авилгын талаарх дуулиан шуугиан, төрийн өндөр дээд түвшний айлчлалууд зэрэг олон чухал үйл явдал илэрхийлж байна.

Монгол Улсын Их хурал 2023 оны 5-р сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталсан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр УИХ-ын гишүүний тоо 76 байсныг 126 болгож, УИХ-ын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулж 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар (улс төрийн намын жагсаалт) сонгохоор шийдвэрлэсэн. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу 2023 онд УИХ-ын сонгуулийн тухай хууль, Улс төрийн намуудын тухай хуулиудыг баталсан. Сонгуулийн тухай шинэ хуульд олон жилийн турш яригдаж ирсэн иргэдийн төлөөлөл, ил тод байдал, шударга ёсны асуудлыг тусгасан. Энэ хуулийн гол шинэчлэл бол өмнө нь 2012 онд мөрдөж байгаад 2016 онд хүчингүй болгосон сонгуулийн холимог тогтолцоотой болсон явдал юм. Холимог тогтолцоог ийнхүү сэргээсэн нь УИХ-ын анхаарлыг сонгуулийн жижиг тойргийн явцуу эрх ашгаас үндэсний бодлого руу чиглүүлэх зорилготой юм. Мөн шинэ хууль нь нэр дэвшигчдийн 30 хувь нь эмэгтэйчүүд байхаар тогтоож УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх зорилго агуулсан. Түүнчлэн тус хууль нь улс төрийн бүх хандив тусламж, ивээн тэтгэгчдийг олон нийтэд ил тод зарлахыг зүйлчлэх замаар сонгуулийн санхүүжилтийн ил тод байдлыг хангахыг зорьсон. Энэхүү алхам нь иргэдийн дунд өргөн хүрээг хамарсан авлигын талаарх эргэлзээ, улс төрийн институцид итгэх итгэл сулрахад нөлөөлөх ашиг сонирхлын зөрчил, зүй бус нөлөөллийг хязгаарлах зорилго тавьсан байна.

Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгад улс төрийн намуудад төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөл шалгуур, хэмжээ, хуваарилалт, гишүүний татвар, хандив, санхүүжилтийн ил тод байдал, төрийн холбогдох байгууллагад тайлан мэдүүлэх зэрэг олон асуудлыг тусгасан. Улс төрийн намуудыг бодлогын

институци болгох зэрэг маргаантай олон асуудлыг Улс төрийн намын тухай хуулиар шийдвэрлэсэн хэмээн улс төр судлаачид дүгнэж байна. Эдгээр өөрчлөлтүүд нь 2024 онд болох УИХ-ын сонгуульд ихээхэн нөлөө үзүүлэхээр байна. Энэ нь янз бүрийн нам, фракцуудын эрх мэдлийн тэнцвэрт байдал, төлөөллийг өөрчлөх магадлалтай. Гэхдээ эдгээр хуулиуд нь ардчиллын үйл явцад шинэ асуудал, сорилт үүсгэж болзошгүй тул алдаатай төдийгүй хангалттай сайжраагүй хэмээн үзэх хэсгүүд ч байна.

Монгол Улсын хувьд улс төрийн намуудын санхүүжилтийн нээлттэй, ил тод байдлыг хангах асуудал нэн чухал болохыг Транспэрэнси Интернэшнл байгууллага тэмдэглэж байна. Улс төрийн томоохон намуудад ардчилал, хариуцлагын механизм төлөвшөөгүй байгаад олон нийт дургүйцэл, бухимдал ихтэй хэвээр байна. Ардчиллын төлөө гэсэн албан ёсны үзэл баримтлалтай хэдий ч улс төрийн намуудад итгэх итгэл олон монголчуудын дунд төдийлөн сайнгүй байгааг олон нийтийн дунд явуулсан судалгаа нотолж байна.

УИХ-д хэт олонх болсон эрх баригч Монгол ардын нам (МАН) нь олон нийтийн болоод сөрөг хүчин болох Ардчилсан нам (АН), ХҮН намуудын шүүмжлэл, сорилттой ихээхэн нүүр тулж байна. МАН нь 2016 оноос хойш УИХ-д олонхи болсон хэдий ч улсын төсөв, төсвийн бодлого, үнийн хямрал, авлига хээл хахуулийн асуудлаас болж нэр хүнд нь нилээд буурсан. АН болон ХҮН намынхны зүгээс авлигын схемийг бүрэн задлахгүй, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглаж, ардчиллыг сүйрүүлж байна хэмээн МАН-ыг буруушааж байна.

АН ийнхүү дургүйцлээ илэрхийлж байгаа хэдий ч харилцан уялдаатай, хэрэгжих боломжтой дорвитой хувилбарыг хараахан дэвшүүлж чадахгүй байна. Түүнчлэн АН-ын дотоод зөрчил, залгамж халаагаа өгөх сонирхол дутмаг, бүтэц зохион байгуулалт нь суларсан зэрэг нь үндсэн сөрөг хүчний үүргээ биелүүлэхэд нь сэргөөр нөлөөлсөн. АН нь дотооддоо дорвитой шинэчлэл хийж, манлайлал гарахгүй байх аваас Монгол Улсын хоёр намын тогтолцоо давамгайлах намын тогтолцоо руу шилжиж магадгүй юм. Нөгөө талаас ХҮН

намын төлөөлөл УИХ-д хүчтэй болсон тохиолдолд хот суурины иргэдийн дунд АН-ын халааг авах улс төрийн шинэ хүчин болж гарч ирж болзошгүй юм. Жижиг болон шинээр төрж буй намуудад дэмжигчид болон хөрөнгө санхүү дайчлах боломж хязгаарлагдмал учир өнөөгийн мөрдөж буй сонгуулийн тогтолцоо тэдэнд том сорилт болох нь гарцаагүй.

Монгол Улсын экспорт, ДНБ-ий багагүй хувийг бүрдүүлдэг нүүрс олборлолтын салбарт өндөр албан тушаалтнууд, бизнес эрхлэгчидтэй холбоотой хээл хахууль, мөнгө завшсан, татвараас зайлсхийсэн гэх дуулиан дэгдэж байна. Ийм буруутгал дуулиан нь Засгийн газраас хариуцлага, ил тод байдлыг шаардаж 2022 оны 12-р сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан томоохон эсэргүүцлийн жагсаалаар эхэлсэн. Эх орондоо амьдрах боломж хомс, тэгш бус байдал, байгаль орчны доройтол улам нэмэгдэж байгаад олон монголчууд бухимдаж буйг энэ жагсаал харуулсан. Улмаар 2023 онд УИХ-ын зарим гишүүнийг нүүрсний хулгай, Хөгжлийн банкны хэрэгт холбогдуулан шалгаж, нийт 76 гишүүнээс нэр бүхий 14 гишүүнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлсэн. Эдгээрээс УИХ-ын нэр бүхий гурван гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх талаар УИХ хэлэлцэж санал хураалт явуулсан.

Транспэрэнси Интернэшнл байгууллагаас гаргасан 2023 оны авлигын төсөөллийн индексээр Монгол Улс нийт 100 оноо авахаас 33 оноо авч 180 орноос 121-д эрэмбэлэгдсэн бол Монгол Улс 2022 онд 116-д, 2021 онд 110-т жагсаж байжээ. Авлигын төсөөллийн индексээр Монгол Улсын эзлэх байр 2022, 2023 онуудад тогтмол буурч, 2021 оноос хойш даруй арван нэгэн байраар ухарчээ. Транспэрэнси Интернэшнл байгууллагын тайланд төрийн албан тушаалтнуудын авлига газар авсан арван орны нэгээр Монгол Улс тодорсон. Авлигын төсөөллийн индексээр улс орнуудын дунд Монгол Улсын эзлэх байр тогтмол ухарч байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, “Таван-Ш” ажиллагаа явуулахаа мэдээлсэн. Үүнд 1) авлигачдыг мэдээлэх шүгэл ажиллагаа, 2) төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах шил ажиллагаа, 3) төрийн албанд хууль бусаар томилогдсон хүмүүсийг илрүүлэх шүүр ажиллагаа, 4) гадаад улс руу оргон зайлсан авлигын гэмт хэрэгтнүүдийг эргүүлэн авчирч хариуцлага хүлээлгэх шувуу ажиллагаа, 5) хууль бус хөрөнгийг илрүүлэн шилжүүлэн авчрах ажиллагаа зэрэг тус тус орсон.



НҮБ-аас төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. © НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

УИХ-аас 2023 оны 6-р сард Авлигатай тэмцэх үндэсний стратегийг шинэчлэн баталсан. Энэхүү стратеги нь Монгол Улсын авлигатай тэмцэх хууль эрх зүйн орчин, институтын чадавхи, олон нийтийн мэдлэг мэдээлэл, олон улсын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэсэн. Уг стратегийг боловсруулахдаа авлигын шалтгаан, үр дагаварт хийсэн иж бүрэн дүн шинжилгээ, иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, эрдэм шинжилгээний байгууллага, гадаадын түншүүд зэрэг янз бүрийн оролцогч талуудаас гаргасан зөвлөмжүүдийг суурь үндэс болгосон. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн 2019 оны шинэчилсэн найруулгын дагуу Монгол Улсын иргэд байгалийн баялгийн үр шимийг хүртэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулсан.

Олон жил маргаан дагуулж байсан Боловсролын тухай багц хуулийг 2023 оны 7-р сарын 7-ны өдөр УИХ-аар баталсан. Боловсролын шинэ хуулиар боловсролыг зөвхөн хичээлийн танхимд бус албан, албан бус, амьдрах орчноос суралцах цогц систем болгон өөрчилсөн. Шинэ хууль нь сургалтын олон талын хэрэгцээг хангах боловсролын уян хатан хөтөлбөрийг хөгжүүлэх, боловсролын үйлчилгээг суралцагчдын сонирхож буй сургалтын хэв маяг, хүсэл эрмэлзэлд нийцүүлэх боломжийг олгоно. Мөн сургуулийн удирдлагын тогтолцоонд шинэчлэлт хийж, сургуулийн захирлыг мерит зарчмаар сонгон шалгаруулах журмыг тусгасан. Багш нарын нийгмийн хамгааллыг сайжруулж, төрийн албанд ажилласан жилээр нь тооцож нэмэгдэл тэтгэмж олгох зохицуулалт хийсэн.

Улсын батлагдсан төсвөөс харахад 2024 оноос эхлэн хөрөнгө оруулалтын дийлэнх төслийг эрчим хүч, зам тээврийн дэд бүтцийн салбарт хэрэгжүүлэхээр тусгажээ. Нийгмийн салбарын хувьд боловсролын салбарт дийлэнх хөрөнгө оруулалт хийгдэхээр байна. “Хөдөөгийн сэргэлт”-ийг дэмжих үүднээс орон нутагт олон жил ажилласан төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэхээр Засгийн газар шийдвэрлэсэн.

Дотоодын эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, ОХУ-ын нефтийн импортын хамаарлаас гарах асуудал нь Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн гол сэдэв болж байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 9-р сарын 13-ны өдрийн хуралдаанаар БНЭУ-ын Экспорт-Импорт банкны зээлийн хөрөнгөөр баригдаж буй Үндэсний газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж, 2027 онд бүрэн ашиглалтад оруулахыг холбогдох салбарын яамдад үүрэг болгосон.

Бүс нутаг болоод дэлхий дахины өөрчлөгдөж буй нөхцөл байдалд Монгол Улсын гадаад бодлого 2023 онд олон сорилт, боломжуудтай тулгарч байлаа. Нэг талаас, Монгол Улс нь хөрш зэргэлдээ ОХУ, БНХАУ-тай холбоо харилцаагаа тэнцвэржүүлэх, ялангуяа Украины дайн болж буй өнөө үед Монголын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх байгалийн хийн хоолойн болон усан цахилгаан станцын төслүүдийг хөгжүүлэхтэй холбоотой харилцаагаа тэнцвэртэйгээр зохицуулах шаардлага тавигдаж байв. Нөгөө талаас, Монгол Улс нь АНУ, Канад, Франц, Япон, БНСУ зэрэг гуравдагч хөрш орнуудтай холбоо харилцаагаа хэвээр хадгалж, худалдаа, хөрөнгө оруулалтын эх үүсвэрээ төрөлжүүлж, ардчиллын үнэт зүйлс, цөмийн зэвсгээс ангид статусаа хадгалан хамгаалахыг зорьж байна.

Монгол Улс гуравдагч хөршийн бодлогыг найрсгаар хөгжүүлж байна. Энэ цаг үед гадаад харилцааг тэнцвэртэй байлгах нь улс орны нэн тэргүүний зорилт хэмээн Ерөнхий сайд тэмдэглэсэн. Монгол Улсын гадаад бодлого нь үндэсний эрх ашиг, бүрэн эрхт байдлаа дээдлэн бататгаж дипломат яриа хэлэлцээ өрнүүлэх, асуудлыг энхийн замаар шийдвэрлэх, бүс нутгийн хамтын ажиллагааг дэмжихэд чиглэж байна. Мөн Монгол Улс нь Ази тивд, ялангуяа Зүүн хойд Ази дахь байр суурь, нөлөөгөө нэмэгдүүлэхийн тулд НҮБ, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ), Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын Суурь конвенцын Талуудын 28-р Бага Хурал (COP28) зэрэг олон улсын байгууллага, форумд идэвхтэй оролцож байна.

3.2 Хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд

Монгол Улсад 1990 оноос хойш батлагдсан салбарын болоод салбар дундын 550 гаруй хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөрийг боловсруулж УИХ, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулжээ. Эдгээр бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх хугацаа харилцан адилгүй байна. Үндэсний хөгжлийн газар (ҮХГ) 2019 онд анх удаа дээрх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, уялдаа холбоо, давхцал зэргийг нарийвчлан шинжилж өөр хоорондоо уялдаагүй, зөрчилтэй цөөнгүй заалтууд, мөн давхцал ихтэй байсныг тогтоосон.

2015 он хүртэл Монгол Улсад хөгжлийн бодлогыг холбогдох салбарын хууль тогтоомжоор зохицуулж ирсэн бөгөөд тус улсад хөгжлийн бодлого боловсруулах үйл явцыг зохицуулах цогц эрх зүйн үндэслэл байсангүй. Монгол Улсын Их Хурал 2015 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталсан нь 1990 оноос хойш улс орны хөгжлийн бодлого төлөвлөлтийн үйл явцыг зохицуулах анхны оролдлого болжээ.

Гэвч Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хууль нь тус улсын хөгжлийн бодлогын уялдаа, зохицол, нэгдмэл байдлыг бүрэн зохицуулж чадахгүй байлаа. Салбарын яамд салбарын бодлого, хөтөлбөрөө дан дангаар боловсруулсан хэвээр байв. Эдгээр бодлого хөтөлбөрүүдийг Сангийн яам (СЯ) болон ҮХГ хянан уялдуулж, нэгдсэн бодлого гаргах боломж ч байсангүй. Нэгдсэн, уялдаатай бодлого боловсруулж, хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт СЯ, ҮХГ-ын зүгээс дэмжлэг үзүүлэх эрх зүйн статус, чиг үүрэг хязгаарлагдмал, чадавхи ч сул байсан аж.

Дээрх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Их Хурал 2020 оны 5-р сард⁵⁰ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль (ХБТТУТХ)-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталж, тус улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцооны хууль тогтоомжид өөрчлөлт оруулсан. Үндсэндээ өөрчлөлтийг хоёр чиглэлээр хийсэн.

Нэгдүгээрт, нэгдсэн, уялдаатай, нийцтэй, урт, дунд, богино хугацааны зохицуулалттай, хөндлөн болон босоо тогтолцооны бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Хоёрдугаарт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл явцыг удирдах институтын тогтолцоог зохицуулж, байгууллагуудын дотоод болон тэдгээрийн өөр хоорондын үүрэг, хариуцлагыг тодорхой болгосон.

Энэхүү ХБТТУТХ-ийн нэмэлт өөрчлөлтийн дагуу Монгол Улсын урт хугацааны хөгжлийн стратеги болох “Алсын хараа 2050”-ыг Улсын Их Хурал 2020 оны 5-р сард баталсан.⁵¹ Алсын хараа 2050 нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын үндсэн чиглэл болж өгсөн.



ХБТТУТХ-ийн дагуу үндэсний хөгжлийн нэгдсэн бодлогыг боловсруулж батлах схемийг Зураг 8-д үзүүлэв.

УИХ-ын 2020 оны 45 дугаар тогтоолоор⁵² Дунд хугацааны сэдэвчилсэн долоон зорилтот хөтөлбөр (10 жил)-ийг боловсруулж 2022 оны 6-р сард багтаан УИХ-аар хэлэлцүүлж батлуулах үүргийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт даалгасан. Эдгээр сэдэвчилсэн зорилтот хөтөлбөрүүдийн нэг (Эдийн засаг, дэд бүтцийн хөтөлбөр) нь 2021 онд УИХ-аар батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”⁵³ юм. Үлдсэн зургаан зорилтот хөтөлбөрийн төслийг Засгийн газрын дэргэд байгуулагдсан салбар дундын ажлын хэсэг 2022-2023 онд боловсруулсан. Одоогоор Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ) эдгээр хөтөлбөрийн төслийг УИХ-д өргөн барихаар эцэслэн боловсруулж байна.


Монгол Улсын 2023 оны Үндэсний сайн дурын илтгэлийг бэлтгэх явцад НҮБ-ын АНДЭЗНК-ийн дэмжлэгтэйгээр Эдийн засаг, хөгжлийн яам (ЭЗХЯ), Үндэсний статистикийн хороо (ҮСХ) Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд зориулж ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлтийн хүрээг дахин шинэчилсэн.

⁵⁰ <https://legalinfo.mn/mn/detail/15403>

⁵¹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15406>

⁵² <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15404>

⁵³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390082551211&showType=1>



Улмаар ЭЗХЯ Монгол Улс дахь НҮБ-ын дэмжлэгтэйгээр эдгээр ТХЗ-ын үндэсний шалгуур үзүүлэлтүүд, зорилтуудын бараг 46 хувийг⁵⁴ нь дээр өгүүлсэн зорилтот зургаан хөтөлбөрт тусгаж чадсан. Эдгээр зорилтот зургаан хөтөлбөрийг УИХ-аар баталснаар өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй салбарын болоод салбар дундын зарим бодлого, стратеги хүчингүй болох юм. Хүчингүй болох бодлого стратегийн жагсаалтыг гаргахаар ЭЗХЯ ажиллаж байгаа бөгөөд зорилтот хөтөлбөрүүдийн төслөө УИХ-д өргөн мэдүүлэхэд тус жагсаалтыг хавсаргаж хүргүүлнэ.

Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг Улсын Их Хурал 2023 оны 5-р сард баталсан.⁵⁵ Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа 2030 он хүртэл хэрэгжүүлэх хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн дунд хугацааны зорилтуудаас жилийн тэргүүлэх чиглэлийг нь авч тусгасан. 2023 оноос эхлэн ЭЗХЯ дунд хугацааны төсвийн хүрээ (ДХТХ)⁵⁶-г боловсруулах үүрэг хүлээж байгаа нь Засгийн газарт хөгжлийн тэргүүлэх чиглэлийг төсөв, төсвийн хүрээтэй уялдуулах боломжийг олгож байна. ДХТХ-нд суурилсан жил бүрийн улсын төсвийн төслийг СЯ боловсруулж байна.

⁵⁴ ЭЗХЯ-ны илтгэл

⁵⁵ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759684400981>

⁵⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16759636332741>

ХБТТУХ-ийн дагуу Засгийн газар 2024 онд Монгол Улсын Таван жилийн (2026-2030) хөгжлийн үндсэн чиглэлийг Төсвийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр (ТХОХ/PIF)-ийн хамт шинээр боловсруулна. Энэхүү дунд хугацааны нэгдсэн бодлого нь 2030 он хүртэл тогтвортой хөгжлийг ахиулах үндэсний хөгжлийн дунд хугацааны тэргүүлэх чиглэл, бодлогын арга хэмжээний бодлогын гол удирдамж хэрэгсэл байх болно. Иймээс ойрын жилийн энэхүү чухал зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газартай Монгол Улс дахь НҮБ нягт хамтран ажиллах шаардлагатай.

Монгол Улс нь ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах тэргүүлэх чиглэлийг⁵⁷ тодорхойлохдоо 2023 онд нийтэлсэн Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэлийн дүн шинжилгээ, хөгжлийн дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөнд туссан хөгжлийн тэргүүлэх чиглэлийг суурь үндэс болгосон. Эдгээр ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах тэргүүлэх зорилтуудыг хэрэгжүүлэхэд НҮБ-ын хөтөлбөр, төслүүдийг чиглүүлснээр Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийн гишүүд хүчин чармайлтаа нэгтгэн улс орны тогтвортой хөгжилд дорвитой нөлөө үзүүлэх боломж бүрдэнэ (ТХЗ-ын хурдасгуур чиглэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 6.1 дэд бүлгээс үзнэ үү).

Монгол Улсын 2023 оны Үндэсний сайн дурын илтгэлд “үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоонд томоохон ахиц дэвшил гарсан”⁵⁸ хэмээн тэмдэглэсэн. ХБТТУХ-д орсон нэмэлт өөрчлөлтүүд нь үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Эдийн засаг, хөгжлийн яамыг 2022 онд байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. Шинэ чиг үүрэг бүхий ЭЗХЯ нь салбарын яамд, төрийн байгууллагуудыг хөгжлийн бодлого төлөвлөгөө боловсруулах арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, үндэсний хэмжээний урт, дунд, богино хугацааны хөгжлийн нэгдсэн бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг зохицуулж байна. ЭЗХЯ нь үндэсний хөгжлийн бодлого төлөвлөлтөд ТХЗ-уудыг тусгах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ хийх асуудлыг удирдан чиглүүлэх, зохицуулах үүрэг хүлээж буй гол яам юм.

ҮСХ нь ТХЗ-ын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох, мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах чиглэлээр арга зүйн болоод мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллахын зэрэгцээ ТХЗ-ын шалгуур үзүүлэлтүүдийг хамруулсан үндэсний хэмжээний ТХЗ-ын мэдээллийн нэгдсэн санг 2019 оноос хариуцан ажиллуулж ирсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12-р сарын 21-ний өдрийн 474 дүгээр тогтоолоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрыг байгуулсан. Тус газар нь 2023 оны эхнээс үйл ажиллагаа явуулж, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, тайлагнах ажлыг эрхлэн гүйцэтгэж байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлдэг Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл (ТХҮЗ)-ийг 2021 оны 1-р сард байгуулж бүрэлдэхүүнд нь НҮБ-ын системийн байгууллагуудын төлөөллийг оруулсан. 2022 онд ЭЗХЯ байгуулагдсаны дараа ТХҮЗ-ийг татан буулгаж, эрхэлж байсан чиг үүрэг, хариуцлагыг ЭЗХЯ-нд шилжүүлсэн. ТХҮЗ-ийн бүрэлдэхүүнд иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллага, НҮБ, Засгийн газрын төлөөлөл орж байсан билээ. ТХҮЗ-ийн эрхэлж байсан чиг үүрэг, хариуцлагыг ЭЗХЯ нэгэнт хүлээж байгаа учир хөгжлийн оролцогч талуудтай хамтран ажиллах, тэдний үзэл бодлыг сонсож, ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмрийг нь хөшүүрэг болгон дэмжих шинэлэг платформтой байх шаардлагатай.

УИХ-ын Тогтвортой хөгжлийн дэд хорооны ажлыг дэмжих зорилгоор УИХ-ын түвшинд Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөлийг 2022 онд байгуулсан хэдий ч тус зөвлөл 2022-2023 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй.

ХБТТУХ-иар ЭЗХЯ-ны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх цогц, системтэй, бодитой бодлогын шинжилгээ хийх чиг үүрэг бүхий “бодлогын судалгааны төв” байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.⁵⁹ Энэхүү төв нь хөгжлийн бодлогын мэдлэгийг зуучлагч, судалгааны төв, шинэ санаа төрүүлэх инкубаторын үүргийг гүйцэтгэх хүлээлттэй байна.

⁵⁷ <https://sdgs.un.org/national-commitments-sdg-transformation/22033>

⁵⁸ <https://hlpf.un.org/sites/default/files/vnrs/2023/VNR%202023%20Mongolia%20Report.pdf> Page 24

⁵⁹ <https://legalinfo.mn/mn/detail/15403>, Chapter 3, 7.3

Энэ төв нь мэдлэг зуучлагчийн хувьд эрдэмтэд, бодлого боловсруулагчид, иргэний нийгмийн хооронд мэдлэг мэдээллийн суваг болж ажиллах юм. Гэвч Монгол Улсын Засгийн газар тус судалгааны төвийг хараахан байгуулаагүй байна. Ийм чиг үүрэг бүхий байгууллага үгүй байгаагаас харилцан уялдаатай, нэгдсэн, бодитой бодлогын шийдвэр гаргахад шаардагдах нотолгоонд суурилсан, цогц, системтэй бодлогын шинжилгээ хийх чиглэлээр ЭЗХЯ, Засгийн газрын чадавхийг бэхжүүлэхэд амаргүй байна.

Тогтвортой хөгжлийн зорилгууд нь өөр хоорондоо харилцан уялдаатай төдийгүй “төрийн нэгдмэл зохицуулалттай байх”, “бүх нийтийн оролцоог хангаж

цогц байх” хандлага, зарчим, системийн сэтгэлгээг шаардана. Иймээс Монгол Улсын Засгийн газар нь бодлогын судалгааны төв байгуулж, мэргэжлийн өндөр чадавхтай хүмүүсийг урьж ажиллуулан, тэдний мэдлэг, ур чадварыг бодлогын шийдвэр гаргахад ашиглах замаар чадавхиа бэхжүүлэх нь чухал. Монгол Улсын Засгийн газрын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр үзүүлж буй дэмжлэгээ Монгол Улс дахь НҮБ цаашид үргэлжлүүлнэ. Монгол Улсын Засгийн газрын 2023 онд шинээр байгуулсан тусгай хороодын жагсаалтыг 1-р хүснэгтэд, 2023 онд Засгийн газрын байгуулсан, бүтцийн өөрчлөлт хийсэн байгууллагуудын жагсаалтыг 2-р хүснэгтэд тус тус үзүүлэв.

Хүснэгт 1. 2023 онд шинээр болон шинэчлэн байгуулсан хороо, агентлагууд

Тогтоолын дугаар	Огноо	Хорооны нэр	Хорооны тэргүүн
155	2023 оны 4-р сарын 26	Уур амьсгалын Үндэсний хороо (Шинэчлэгдсэн)	С. Амарсайхан. Монгол Улсын Шадар сайд
305	2023 оны 8-р сарын 23	Боловсролын Үндэсний хороо (Шинэчлэгдсэн)	Монгол Улсын Ерөнхий сайд
241	2023 оны 6-р сарын 21	Хот, хөдөөгийн сэргэлт, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн Үндэсний хороо	Монгол Улсын Ерөнхий сайд
215	2023 оны 6-р сарын 7	Олон улсын Монголч эрдэмтдийн XII их хурлыг зохион байгуулах үндэсний хороо	Боловсролын сайд

Хүснэгт 2. 2023 онд шинээр болон шинэчлэн байгуулсан байгууллагууд

Тогтоолын дугаар	Огноо	Байгууллага	Байгууллагын тэргүүн
37	2023 оны 2-р сарын 1	Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллага – Хөрөнгө оруулалт, худалдааны газар	В. Энхбаатар, ЭЗХЯ-ны харьяа
96	2023 оны 3-р сарын 15	Монгол Улсын Усны үйлчилгээг зохицуулах хороо (Бүтцийн өөрчлөлт хийсэн)	Г. Цогтсайхан, Засгийн газрын байгууллага
10	2023 оны 1-р сарын 5	Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллага – Монгол Улсын Шүүх шинжилгээний ерөнхий газар (Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн татан буугдсан)	Ж. Буянбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа

4 БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ




4.1 Бүс, орон нутгийн хөгжлийн асуудал

Монгол Улсын ТХЗ-ын хэрэгжилтийн хоёр дахь удаагийн ҮСДИ-ийн нэг бүлэгт ТХЗ-ын хэрэгжилтийг хязгаарлах хүчин зүйл болж буй бүс, орон нутгийн хөгжлийн асуудал, сорилтод дүн шинжилгээ хийсэн.

Монгол Улс сүүлийн хэдэн арван жилд хурдацтай хотжиж ирснээр хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрт байдал алдагджээ. Хот суурин газруудад 1970 онд нийт хүн амын 44 орчим хувь, 1990 онд нийт хүн амын 57 хувь нь амьдарч байсан бол 2020

оны байдлаар нийт хүн амын 69 хувь нь амьдарч байгаа бөгөөд үүний 46 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байна. Цаашид бүс нутгийн хөгжил, хүн амын суурьшилтай холбоотой орон зайн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тодорхойгүй байдал энэ хэвээр үргэлжилбэл 2045 он гэхэд нийт хүн амын 80 орчим хувь нь хот сууринд суурьших төдийгүй бусад бүс нутагт хүн амын өсөлт ажиглагдахгүй байх төлөвтэй байна (Зураг 9).

Зураг 9. Хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар хот, аймгийн төвүүд, хөдөө орон нутгаар, 1990-2045



(Эх сурвалж: Монгол Улсын хоёрдахь удаагийн ҮСДИ, 2023)

Бүс, орон нутгийн хөгжлийн асуудлаар хийсэн шинжилгээний үндсэн үр дүнг дараах байдлаар нэгтгэв. Үүнд:

- 1) Нутаг дэвсгэрийн нийгмийн хөгжлийн ялгаа эрс нэмэгдэж, хөдөө, орон нутагт боломж сонголт хомс байна.
- 2) Хөдөө орон нутагт ган, зуд зэрэг “түлхэх хүчин зүйлс” давамгайлж, Улаанбаатар хотод боловсрол, соёл урлаг, ажлын байр зэрэг “татах хүчин зүйлс” төвлөрч, сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд хөдөө орон нутгаас хот суурин руу

чиглэсэн дотоод шилжилт хөдөлгөөн нэмэгдсэн байна.

- 3) Сум гэх эрх зүйн статустай эдийн засаг, нийгмийн хөгжлөө төлөвлөх эрх зүйн чадамжгүй суурингууд байна. Бүс, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд орон нутгийн суурингуудын гүйцэтгэх үүрэг тодорхой бүс байгаа нь Улаанбаатар хотын төвлөрлийг улам нэмэгдүүлэх хандлагатай байна (Бүс нутгийн хөгжлийг дэмжих талаарх иргэдийн байр суурийг Шигтгээ 1-ээс үзнэ үү).

- 4) Монгол Улсын аж үйлдвэрийн салбарыг, тухайлбал, хүнсний болон боловсруулах үйлдвэрлэлийг бүс орон нутгийн түвшинд хөгжүүлэх орон зайн бодлого, төлөвлөлт тодорхой бус байна.
- 5) Тээврийн дэд бүтцийн босоо, хөндлөн тэнхлэг, түүнд суурилсан зам, тээврийн сүлжээ, хилийн боомт, чөлөөт бүс, ложистикийн нэгдсэн сүлжээ бий болоогүй байна
- 6) Бүс, орон нутагт хүн ам шилжин суурьших, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэрэгсэл, механизм тодорхой бус байна.
- 7) Эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх бодлого, төлөвлөлт, хууль эрхзүйн орчин, бүс нутгийн түвшин дэх эрх, үүргийн хуваарилалт тодорхой бус, институтийн тогтолцоо бүрдээгүй байна.

Шигтгээ-1

Үндэсний зөвлөлдөх санал асуулга зохион байгуулагдсан.

УИХ-аас “Зөвлөлдөж шийдье” улсын хэмжээний зөвлөлдөх санал асуулгыг зохион байгуулав. Тус санал асуулгад санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон 1750 хүн оролцсон бөгөөд тэд 4 бүлэгт хуваагдаж нийт 22 асуултад хариулт өгсөн.

Бүс, орон нутгийн хөгжил, төвлөрлийг сааруулахтай холбоотой 3 асуултад иргэд хариулж оролцсон. “Орон нутаг дахь ЖДҮ-ийг дэмжих зорилгоор уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос сан бүрдүүлж ажиллахыг Та дэмжиж байна уу?” гэсэн асуулт 0.885 оноогоор дэмжигдсэн. Мөн “Төвлөрлийг сааруулж бүсчлэн хөгжүүлэхтэй холбоотойгоор засаг захиргааны шинэчлэл хийхийг Та дэмжиж байна уу?” гэсэн асуулт 0.869 оноогоор дэмжигдсэн.

Зөвлөлдөх зөвлөлөөс дараах зөвлөмжийг УИХ-д хүргүүлжээ. Үүнд:

- Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын орлогоос орон нутаг дахь жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сан бүрдүүлэх эрх зүйн орчныг бий болгох;
- Засаг захиргааны шинэчлэл хийх саналыг Засгийн газар боловсруулж, УИХ-аар шийдвэрлүүлэх.
- Улаанбаатар хотын төвлөрлийг бууруулахын тулд орон нутагт оршин суугч болон шилжин суурьшигч иргэдэд тусгайлсан дэмжлэг үзүүлэх эрхзүйн орчныг боловсронгуй болгох

(Эх сурвалж: Монгол Улсын хоёрдахь удаагийн ҮСДИ, 2023)

Хоёр дахь удаагийн ҮСДИ-ийн хүрээнд хийсэн дүн шинжилгээний үр дүнг үндэслэн бүс, орон нутгийн хөгжлийн хэд хэдэн шийдэл, зөвлөмжийг дэвшүүлсэн. Үүнд:

- 1) Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хуулийг шинэчлэн найруулж, бусад хууль тогтоомжтой уялдуулах;
- 2) Хүнсний болон хөнгөн үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх газарзүйн тохиромжтой байршлыг тодорхойлох замаар бүс, орон нутгийн түвшинд иргэд-бизнес эрхлэгч нарын кластер хамтын ажиллагааг бэхжүүлэх,
- 3) Хөгжлийн орон зайн төлөвлөлтөд баримтлах бодлого, зураглалыг тодорхой болгож, зарлан мэдээлэх;
- 4) Хот сууринд зэрэглэл, статус тогтоож, тэдгээрийн нийгэм, эдийн засгийн хөгжилд гүйцэтгэх үүргийг тодорхой болгох;
- 5) Бүсийн нийгэм, эдийн засгийн хөгжил, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортыг дэмжсэн тэнхлэгт суурилсан тээвэр-ложистикийн нэгдсэн сүлжээ бий болгох;
- 6) “Хот” төвтэй кластер бүсүүдийг тодорхойлж, хөрөнгө оруулалтаар дэмжих;
- 7) Бүс, орон нутгийн түвшинд зангидах холболтын эдийн засгийг бий болгох. Бүс нутгийн хөгжлийн хүчин зүйлс нь бүс, орон нутгийн түвшинд харилцан уялдаж, биенээ дэмжих эдийн засаг-дэд бүтцийн газарзүйн кластер холболтуудыг нөхцөлдүүлэх замаар бүс орон нутгийн “татах хүч”-ийг бий болгох;
- 8) Хөгжлийн орон зайн төлөвлөлтийн үндсэн концепцид суурилсан эрхзүй, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх арга хэрэгслүүдийг зарлан мэдээлэх;

4.2

ТХЗ-ын хэрэгжилтийн хоёр дахь удаагийн ҮСДИ-ийн үр дүнг ашиглахдаа анхаарах зарим асуудал, цаашдын алхам

ҮСДИ-ийн дүн шинжилгээг хийхдээ холбогдох олон байгууллагын урьд өмнө хийсэн судалгаанд үндэслэсэн. Иймээс ҮСДИ-ийн судалгаа шинжилгээний үр дүн, зөвлөмжийг боловсруулахдаа бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн асуудлаарх өнгөрсөн үеийн бодлого, шийдвэрээс авсан сургамжид суурилсан болно.

Сүүлийн хорь гаруй жилийн хугацаанд тасралтгүй, тууштай өсөн нэмэгдэж буй хөгжлийн олон сорилттой Монгол Улс нүүр тулж ирсэн. Эдгээр сорилтын нэг бол бүс нутгийн хөгжил сул байсан явдал юм. Монгол Улсын Засгийн газрын зүгээс хөдөө, хотын ялгааг арилгах, хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, Улаанбаатар хотод тулгарч буй олон

асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн бодлогын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд тэргүүлэх ач холбогдол өгөх шаардлагатай байна.

ҮСДИ-ийг боловсруулах явцад бүс нутгийн дотоод, гадаад эдийн засгийн харьцангуй давуу тал, хилийн боомтуудтай холбогдох боломж зэрэгт суурилсан эдийн засгийн өртгийн сүлжээний дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал байсан. Цаашид ийм төрлийн судалгаа шинжилгээ хийх нь Монгол Улсын Засгийн газар уялдаа холбоо бүхий бодлогын шийдвэр гаргахад тустай байх нь гарцаагүй.

Засгийн газраас бүсчилсэн хөгжлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх замаар бүс нутаг, хөдөөгийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах арга хэмжээг авах нь чухал юм. Үүнд:

1

Аймаг бүрийн хөрөнгө нөөц, эдийн засгийн харьцангуй давуу тал, эдийн засгийн өсөлттэй төвүүд, хилийн боомттой холбогдох боломж зэрэгт суурилсан өртгийн сүлжээнд судалгаа шинжилгээ хийх;

2

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах дэд бүтэц, зам тээвэр, эрчим хүч, төсөв, татварын бодлого зэрэг чиглэлээр хэрэгжүүлэх зорилтот бодлогын арга хэмжээг тодорхойлох;

3

Аймгууд, ялангуяа өсөлтийг дэмжих төвүүдэд төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхийг эн тэргүүний зорилт болгон хүний амьдрах таатай орчныг бүрдүүлэх;

4

Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний цогц бодлогыг боловсруулж бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжих;

Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжих жил болгон зарлаж, “бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг шинэчлэн боловсруулж УИХ-ын 2024 оны хаврын чуулганаар хэлэлцүүлж батлуулахаар зорьж байна. 2024 оны 2-р сарын 1-2-нд зохион байгуулагдсан

Монголын эдийн засгийн чуулган бүсчилсэн хөгжилд анхаарал хандуулж бүсчилсэн хөгжлийн шинэчилсэн үзэл баримтлалд тусгахаар 6 бүсийн (баруун, хангай, хойд, төв, өмнөд, зүүн) тэргүүлэх чиглэлийн салбарыг тодорхойлсон.

5 ХЭНИЙГ Ч ОРХИГДУУЛАХГҮЙ БАЙХ ЗАРЧИМ, ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ
ҮЙЛДЛЭЭРЭЭ НЭГДЬЕ!



НӨГДСЭН ҮНДЭСНИЙ
БАЙГУУЛАГА
МОНГОЛ УЛС



1 АДУУРЛЫГ
УСТГАХ

2 ӨЛСГӨЛӨНГ
УСТГАХ

3 ЭМНЭДИЙГ
СЭХЭГ

4 ЧАНАРТАЙ
БОЛОВСРОЛЫГ
ДЭМЖИХ

5 ЖЕНДЕРИЙН
ЭРХ ТЭГШ
БАЙДЛЫГ
ХАНГАХ

6 БАГААГАД ҮНДЭРНИЙ
АРИУН ЦӨГӨРИЙН
БАЙГУУЛАГААР
БАНГАХ

7 ГАЗРАГ
ТАЙГАЙН
ЭНЭРГИЙГ
ХАМГААХ
ТАЙГАЙН
ЭНЭРГИЙГ
ХАМГААХ

8 ЭДИЙН
ЭХЭЛЭЙН
ӨСӨЛТ
ЭХЭЛЭЙН
ӨСӨЛТ

9 ӨГӨС
ЭХЭЛЭЙН
ӨСӨЛТ
ЭХЭЛЭЙН
ӨСӨЛТ

10 ХӨГЖИЛ
ТАЙГАЙН
ЭНЭРГИЙГ
ХАМГААХ
ТАЙГАЙН
ЭНЭРГИЙГ
ХАМГААХ

11 ХӨГЖИЛ
ТАЙГАЙН
ЭНЭРГИЙГ
ХАМГААХ
ТАЙГАЙН
ЭНЭРГИЙГ
ХАМГААХ

12 ХАРИУЦЛАГААЙ
ҮЙЛДЭГЭЛЭЛ
ХЭРГЭЛЭЭГ
ДЭМЖИХ

5 ЖЕНДЕРИЙН ЭРХ
ТЭГШ БАЙДЛЫГ
ХАНГАХ

3 ЭРҮҮН
ДЭМЖИХ



Улаанбаатар хотын захын хорооллуудад нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал байна.
©Д.Давааням/ Noise Art Media

ТХЗ-ын хэрэгжилтийн хоёр дахь удаагийн ҮСДИ-ийг бэлтгэх явцад чанарын болон тоон судалгаа явуулж нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, хоцрогдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийг тодорхойлсон. Хөдөөгийн, амьжиргааны түвшин доогуур (хамгийн бага орлоготой 40 хувьд хамрагдаж байгаа) өрхийн бага боловсролтой, дунд эргэм насны эрэгтэйчүүд хөгжлийн хувьд хамгийн орхигдох эрсдэлтэй бүлэгт орж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, дотоодын шилжигчид, хүүхдүүд, орон гэргүй тэнэмэл хүмүүс (боловсрол муутай, архинд донтсон, гэр бүлийн хүчирхийллийн золиос болсон, засан хүмүүжүүлэх газраас суллагдсан, асрамжийн газраас насанд хүрээд гарсан) зэрэг хүн амын бүлгүүд анхаарлын гадна орхигдох хамгийн өндөр эрсдэлтэй байгааг тодорхойлсон. Иргэний нийгмийн байгууллагуудын 2022 онд хийсэн ТХЗ-ын хэрэгжилтийн тайланд хүүхэд, залуучууд, охид, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ахмад настан, хотын захын болон хөдөө орон нутгийн иргэд, сэтгэцийн өвчтэй болон лесбиян, гей, бисексуал, трансжендер, кюийр, интерсекс (ЛГБТКИ+) хүмүүс нийгмийн хөгжлөөс орхигдох эрсдэл өндөр байна хэмээн тодорхойлсон.⁶⁰

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй нийт 115115 хүн (2023)⁶¹ амьдарч байгаа бөгөөд тэд нийгмийн хөгжлөөс орхигдох эрсдэл хамгийн өндөр, эмзэг бүлэгт хамрагдсан хэвээр байна. Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй олон өрх буюу тэдний 40 гаруй хувь нь хамгийн бага орлоготой өрхүүдэд амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс зохистой орон сууцтай болох боломж тун хязгаарлагдмал байна. Орон сууцны талаар төрөөс баримталж буй бодлого нь тусгай хэрэгцээтэй, орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүдийн онцлог хэрэгцээг хангаж чадахгүй байна. Монгол Улсад хэрэгжиж буй орон сууцны талаар төрөөс баримталж буй бодлогод нийтийн орон сууцны тодорхой хэсгийг (5 хувь) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тусгайлан хуваарилж байх заалттай. Хувийн хэвшлийн орон сууцны төслүүдэд хамрагдах боломж ихэвчлэн хязгаарлагдмал, өндөр өртөгтэй төдийгүй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмж муутай, тохиромжгүй байна. Төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны шугамд холбогдоогүй гэр хороололд (уламжлалт байшин) хөгжлийн бэрхшээлтэй олон хүн амьдарч байна.

⁶⁰ ТХЗ, ИНБ-ын Сүлжээ (2022). Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан.

⁶¹ Үндэсний статистикийн хороо. Хүн амын статистик 2023.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орон сууцыг дэмжих шинэ хөтөлбөрийг Монгол Улсын Засгийн газар 2023 оны 7-р сард баталсан. Монгол Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй орон сууцны энэхүү хөтөлбөр нь аль болох хөгжлийн бэрхшээлтэй олон иргэд, тэдний гэр бүлийн гишүүдийн амьдралын чанар, нөхцөлийг сайжруулах зорилготой. Тус хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан хуваарилах нийтийн орон сууцны 5 хувийг 15 хувь болгож нэмэгдүүлэхийг зорьж байна. 2024 оноос хэрэгжиж эхлэх уг хөтөлбөрийг хоёр жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд энэ хугацаанд явцын үр дүнд үнэлгээ хийж Засгийн газрын түвшинд танилцуулна.

2023 оны 8-р сарын 14-нөөс 9-р сарын 8-ны хооронд зохион байгуулагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн (НҮБ-ын ХБХЭК) 29 дүгээр чуулганд конвенцийн хэрэгжилтийн тайлангаа хэлэлцүүлсэн найман улсын нэг нь Монгол Улс юм. Монгол Улсын Засгийн газар үндэсний тайланг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн хоёр байгууллага хараат бус тайланг тус тус бэлтгэж ХБХЭНҮБК-ийн албанд хүргүүлсэн. НҮБ-ын ХБХЭК-ийн алба Монгол Улсын үндэсний тайланг судалж үзээд, 2023 оны 9-р сард эцсийн дүгнэлтээ гаргасан. Тус дүгнэлт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх сөрөг ойлголтыг бий болгоход хүргэж буй тогтолцооны хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн Монгол Улс дахь НҮБ болон иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс гаргаж буй хүчин чармайлтыг өргөжүүлэхэд гол түлхэц болно.

Иргэний нийгмийн байгууллагууд, төрийн албан хаагчид, хөгжлийн түншүүд хамтран 2023 оны 11, 12-р сард гурван удаа хэлэлцүүлэг зохион байгуулж, НҮБ-ын ХБХЭК-ийн албанаас ирүүлсэн зөвлөмжүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх талаар хэлэлцсэн. Хэлэлцүүлгийн явцад эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хугацаа, хариуцлагыг тодорхойлсон үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулах талаар оролцогчид зөвшилцсөн. НҮБ-ын ХБХЭК-ийн албанаас ирүүлсэн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөөг одоогоор Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий

газар (ХБХХЕГ) боловсруулж байна. Тус төлөвлөгөө 2024 оны 3-р сар гэхэд бэлэн болох бөгөөд түүнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенцийн (ХБХЭНҮБК) дараагийн чуулган хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ. Хүний эрхийн дээд комиссарын газар (ХЭДКГ/ОНСНР)-ын Surge санаачилга нь тогтвортой хөгжлийг сааруулж буй тэгш бус байдлыг арилгах чиглэлд Монгол Улсын Засгийн газрын нөлөөлөл сурталчилгааны ажлыг дэмжих, НҮБ-ын ХБХЭК-ийн албанаас ирүүлсэн бүх зөвлөмжийг хэрэгжүүлэх үндэсний зохицуулалт, төлөвлөлтийн үндэс болох цогц бодлого, тодорхой хугацаатай, стратеги төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэхийг зорьж байна.

Монгол Улс жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлд зарим ахиц гаргаж байна. Монгол Улсын Жендэрийн тэгш бус байдлын индекс 0.297 болж 2022 онд 166 орноос 72-т эрэмбэлэгдсэн (2021 онд 0.303 байснаас бага зэрэг ахисан).⁶² Гэсэн хэдий ч жендэрт суурилсан хүчирхийллийн түвшин өндөр, эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо сул байгаа нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад саад тээж байна. Монголд эрэгтэй, эмэгтэй хүмүүс соёлын хэм хэмжээ, жендэрийн талаарх хэвшмэл ойлголтоос шалтгаалж, хөдөлмөрийн хуваарилалт, үүрэг, хариуцлагын хувьд харилцан адилгүй саад бэрхшээлтэй нүүр тулж байна. Эмэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцоо, боловсролын түвшин эрэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй өндөр буюу олон улс орныхоос ялгаатай байгаа хэдий ч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хөдөлмөрийн хуваарилалтад жендэрийн ялгаа байсаар байна. Хөдөлмөрийн зах зээл дэх ажил мэргэжил дээр ч жендэрийн ялгаа ажиглагдаж байна. Албан бус салбарт эмэгтэйчүүд зонхилж байгаагийн зэрэгцээ үйлчилгээний болон эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүд илүү олноор ажиллаж, гэр бүл, хүүхэд асрах ажлын гол хариуцлагыг эмэгтэйчүүд үүрч байна. Удирдах дээд албан тушаал, улс төр, эдийн засгийн салбарын шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд цөөн төлөөлөлтэй байгаа нь жендэрт суурилсан хэвшмэл ойлголт, соёлын хэм хэмжээ, зан үйлээс шалтгаалж байна. Баялгийн тэгш бус хуваарилалт, ужгирсан ядуурал, хүн амын зарим бүлгийг ялгаварлах, үл хайхрах үзэгдэл ажиглагдаж байгаа зэрэг нь эмэгтэйчүүд, ерх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд том сорилт болсон хэвээр байна.

⁶² <https://hdr.undp.org/data-center/specific-country-data#/countries/MNG>

Монгол Улсын бүх шатны шийдвэр гаргах түвшинд, ялангуяа УИХ-ын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангах зорилт биелэгдэхэд амаргүй хэвээр байна. Сонгуульд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтад жендэрийн 20 хувийн квот тогтоож байсан ч Монгол Улсын Их хурал дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл дөнгөж 17 хувийг л бүрдүүлж чадсан. Парламент хоорондын Холбооны тооцоогоор УИХ хурал дахь эмэгтэй гишүүдийн тоогоор Монгол Улс 186 орноос 134-т жагссан нь харамсмаар буюу жендэрийн эрх тэгш байдлыг хангах ойрын ирээдүй бүрхэг байгааг илэрхийлж байна. Монгол Улс дахь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зүгээс УИХ-ын сонгуулийн тухай болон Улс төрийн намын тухай хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахад чиглэсэн дэмжлэгийг Монгол Улсын Засгийн газарт үзүүлж ирсэн. Үүний үр дүнд эдгээр хуулиудад жендэрийн квотыг 2024 оны сонгуульд 30 хувь, 2028 оны сонгуульд 40 хувь байхаар шинэчлэн тогтоох, намууд нэр дэвшигчдийн жагсаалтад эрэгтэй, эмэгтэйчүүдийг солбиулж (цахилгаан товч систем) оруулах, эмэгтэй нэр дэвшигчдийг хураамжаас чөлөөлөх зэрэг нөлөө бүхий олон арга хэмжээ, улс төрийн намууд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үүрэг хүлээх зэрэг чухал заалтууд оруулсан.

Монгол эмэгтэйчүүдийн талаас илүү хувь нь амьдралынхаа аль нэг үед хүчирхийллийн ямар нэгэн хэлбэрт өртөж байсан бөгөөд байнгын хамтран амьдрагчтай эмэгтэйчүүдийн 31.2 хувь нь дотны хамтрагчийнхаа зүгээс бие махбодийн болон бэлгийн хүчирхийлэлд өртөж байсан тухай судалгааны тайланд тэмдэглэсэн байдаг. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, бодлогыг бүрэн хэрэгжүүлэхэд санхүүжилт хангалтгүй, мэргэжлийн чадавхи сул байгаа зэрэг саад тээг болж байна. Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх зорилгоор олон салбарын үйлчилгээг бэхжүүлэх чиглэлээр ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн хэдий ч тэдний зарим хэсэг нь буюу нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйлчилгээ хүчирхийллийн хохирогч болсон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бүрэн хүрэхгүй байна.

Нийгэмд угширсан ялгаварлан гадуурхсан хэм хэмжээ, хандлага давамгайлж байгаа нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүд, охид, ялангуяа нэн эмзэг бүлгийн хүн ам хэрэгцээт үйлчилгээгээ авах эрхээ эдлэхэд саад учруулж байна.

НҮБ-ын Хүн амын сангийн Ази Номхон далайн бүсийн төлөөлөгчийн газрын техникийн дэмжлэгтэйгээр ҮСХ болон Монгол Улс дахь НҮБ-ын Хүн амын сан хамтран 2017 онд явуулсан Жендэрт суурилсан хүчирхийллийн тархалтын судалгааны мэдээлэлд 2023 онд гүнзгийрүүлсэн дүн шинжилгээ хийсэн. Энэхүү гүнзгийрүүлсэн шинжилгээг хийхдээ судлаачид жендэрт суурилсан хүчирхийлээс сэргийлэх хамгаалалтын хүчин зүйлс болон жендэрт суурилсан хүчирхийлэлд хүргэж болзошгүй эрсдэлт хүчин зүйлсийг судалсан байна.

Гэр бүлийн бат бөх харилцаа нь хамгаалах хүчин зүйлсийн нэг болж байсан бол бага балчир насандаа хүчирхийлэлд өртөх нь насанд хүрсэн үедээ жендэрт суурилсан хүчирхийлэлд өртөх эрсдэлт хүчин зүйл болж байгааг тогтоожээ. Уг гүнзгийрүүлсэн шинжилгээний үр дүн нь жендэрт суурилсан хүчирхийлэл гарч буй үндсэн шалтгааныг таслан зогсоох, хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх үр дүнтэй стратеги боловсруулах чухал нотолгоо болсон. Шинжилгээний үр дүнг холбогдох оролцогч талууд хүлээн зөвшөөрч, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлд тусгахаар 2023 оны 12-р сарын 7-ны өдөр УИХ-ын танхимд цугларсан шийдвэр гаргагчид батламжилсан. Жендэрийн эрх тэгш байдлыг хангахад дагаж мөрдөх стандартын доод хязгаар хангагдаж байгаа эсэхэд Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийн хийсэн үнэлгээний дүнг Шигтгээ 2-т үзүүлэв.

Монголын залуучууд, ялангуяа хөдөө орон нутгийн хүн амын цөөнгүй хэсэг нь дижитал хуваагдалд орж байна. Дижитал дэд бүтцийг сайжруулах, дижитал бичиг үсгийн боловсролыг сургалтын хөтөлбөрт оруулах санаачилга гаргах нь чухал байна. Ингэснээр дижитал хэрэгсэл, хөрөнгө нөөц тэгш хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлж, хөгжиж буй дижитал ертөнцөд залуучуудыг бэлтгэх болно. Ялангуяа уул уурхай, хөдөө аж ахуйгаас бусад салбарт шаардагдах ур чадварыг Монголын залуучуудад эзэмшүүлэхийн тулд дижитал бичиг үсгийн боловсрол, аж ахуй эрхлэх боловсролыг дээшлүүлэх чиглэлээр санаачилгатай ажиллах нь чухал байна. Шинээр хөгжиж буй дижитал технологид чиглэсэн мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүдийг хөгжүүлснээр залуучуудыг эрх мэдэлжүүлэх, инновацийг дэмжих, Монгол Улсын эдийн засгийн хамаарлыг төрөлжүүлэх боломж бүрдэнэ.

Шигтгээ-2

Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийн Жендэрийн эрх тэгш байдлын үнэлгээ (UNCT-SWAP)

2023 онд НҮБ-ын системд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад дагаж мөрдөх стандартын доод хязгаар (UNCT SWAP minimum) хангагдаж байгаа эсэхийг үнэлэх судалгааг (UNCT-SWAP) хийсэн. Энэхүү судалгааг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн зохион байгуулалтын удирдлага дор НҮБ-ын хамтарсан үйл ажиллагааны талаарх суурь мэдлэгтэй, төрөл бүрийн салбар, чиг үүрэг бүхий НҮБ-ын 9 байгууллагын (НҮБ-ын Хүн амын сан, НҮБ-ын Хүүхдийн сан, ОУХБ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, ДЭМБ, ОУШХБ, НҮБ-Эмэгтэйчүүд) төлөөлөл болох 17 гишүүнээс бүрдсэн байгууллага хоорондын үнэлгээний баг хийсэн.

UNCT-SWAP үнэлгээ нь улс орны хэмжээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн төлөвлөлт, зохицуулалт, хөтөлбөр, үр дүнг сайжруулахад чиглэсэн хариуцлагын тогтолцоо юм. Цуглуулсан тоо мэдээлэлд тулгуурлан Монгол Улс дахь НҮБ-ын гүйцэтгэлийг 7 чиглэлээр, нийт 15 стандарт үзүүлэлтээр шинжилгээ хийсэн. Ийм үнэлгээг НҮБ-ын ТХХАХ хэрэгжих мөчлөгийг бүхэлд нь хамруулж НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэх хугацаанд нэг удаа хийх юм.

Монгол Улс дахь НҮБ-ын гүйцэтгэл ерөнхийдөө эерэг байна. Гүйцэтгэлийн 15 үзүүлэлтээс 3 үзүүлэлт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангахад дагаж мөрдөх стандартын доод хязгаарт хүрээгүй; 5 үзүүлэлт стандартын доод хязгаарт ойртсон; 5 үзүүлэлт стандартын доод хязгаарыг хангасан; 2 үзүүлэлт стандартын доод хязгаараас дээгүүр үзүүлэлттэй байна. Стандартын доод хязгаарыг хангаагүй 3 үзүүлэлт нь: Хүний нөөцийн жендэрийн харьцаа, Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын багийн Жендэрийн үзэл баримтлалыг төлөвшүүлэх чадавх, Жендэрийн үзэл баримтлалыг төлөвшүүлэх хөрөнгө нөөц. Тус үнэлгээгээр Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын баг нь 4 үзүүлэлтийг хангаагүй гэж дүгнэсэн. Үүнд: Жендэрийн эрх тэгш байдлыг хангаж, эрх мэдэлжүүлэхэд чиглэсэн хамтарсан хөтөлбөр (GEWE); хүний нөөцийн жендэрийн харьцаа; жендэрийн бүтэц, чадавх; нөөцийн хуваарилалт зэрэг хамаарна. Энэ чиглэлээр НҮБ-ын ТХХАХ-г хэрэгжүүлэх хугацаанд НҮБ-ын Удирдлагын баг илүү хүчин чармайлт гаргаж ажиллах шаардлагатай.

Бүсчилсэн хөгжлийг дэмжих хүрээнд боловсролын хүртээмж, ажлын байр, нийгмийн үйлчилгээний хүртээмж зэрэг хот, хөдөөгийн залуучуудад тулгарч буй асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Бүс нутгийн ялгаатай байдлыг арилгах, нийт бүс нутгуудад залуучууд хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлж сайжруулахад чиглэсэн хууль эрх зүйн болон бодлогын орчныг бүрдүүлэх хэрэгтэй.

Монгол Улс залуучуудад ур чадвар эзэмшүүлж, хүн ам зүйн бүтцийн давуу талаа бүрэн ашиглахын тулд залуучуудад үр бүтээлтэй, зохистой хөдөлмөр эрхлэх хангалттай боломж нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ төлөвлөөгүй

жирэмслэлтээс сэргийлэхийн тулд жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл хэрэглэх эрхийг нь хүндэтгэж хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх шаардлагатай.

Сургууль завсардалт, ажилгүйдэл, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, эрт гэр бүлийн амьдралд орох зэрэг эрсдэлд өсвөр үеийнхэн, залуучууд, ялангуяа орхигдох эрсдэлтэй хүн амын бүлгүүд илүү өртөмтгий байна. Тэдэнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ, нөхөн үржихүйн эрхийн талаарх үнэн зөв, цогц мэдээлэл дутмаг төдийгүй өөрсдийнх нь аж амьдралд нөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах үйл явцад оролцох нь хязгаарлагдмал хэвээр байна.

Судалгаанд хамрагдсан өсвөр насны охидын 55 хувь нь хамтрагчийнхаа хараа хяналтад орж байсан мэдээлэл байна.

Монгол Улсын төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогын хүрээнд сүүлийн үед хийсэн бүтцийн өөрчлөлтөөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар болгон өөрчилсөн. Энэхүү бүтцийн өөрчлөлт нь гэр бүл, хүүхдийн халамжид илүү анхаарсан стратегийн шинэчлэл болсон бөгөөд залуучуудын хөгжлийн тодорхой чиг үүргийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын

сайдын дэргэд шинээр байгуулагдсан Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан албанд шилжүүлсэн. Эдгээр өөрчлөлтүүд нь бодлогын дасан зохицох динамик хандлагыг тусгасан хэдий ч залуучуудыг эрх мэдэлжүүлэхэд үзүүлэх тэдгээрийн нөлөөллийг тасралтгүй үнэлж байх шаардлагатай. Ялангуяа дижитал бичиг үсгийн боловсрол, бизнес эрхлэх чиглэлээр ур чадварыг хөгжүүлэх, дэлхийн эдийн засгийн чиг хандлагад нийцүүлэх, байгаль орчны бодлого боловсруулахад залуучуудын оролцоог идэвхжүүлэн бэхжүүлэх зэрэг салбарт онцгой анхаарал хандуулах нь нэн чухал юм.



Залуучуудад зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

© НҮБ-ын Хүн амын сан

6 | ТХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТЭД ГАРСАН АХИЦ ДЭВШИЛ



6.1 Хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэл, үндэсний зорилт, ТХЗ-ын хурдасгуурууд

Монгол Улсын Засгийн газар Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн хоёр дахь удаагийн Үндэсний сайн дурын илтгэлээ⁶³ Монгол Улс дахь НҮБ-ын дэмжлэгтэйгээр бэлтгэж 2023 онд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн улс төрийн дээд хэмжээний чуулга уулзалтад танилцуулж хэлэлцүүлсэн. Энэхүү хоёр дахь удаагийн ҮСДИ-ийн дүгнэлтэд үндэслэн Монгол Улсын Засгийн газар Монгол Улс дахь НҮБ-ын дэмжлэгтэйгээр үндэсний хөгжлийн тэргүүлэх гурван зорилт, ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах 12 тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Үндэсний хөгжлийн тэргүүлэх гурван зорилт нь 1). ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах 12 тэргүүлэх чиглэлийг баталж, хэрэгжүүлэх, 2). 2030 он гэхэд үндэсний ядуурлын түвшинг 15 хувь хүртэл бууруулах, 3). институцийн тогтолцоог бэхжүүлж ТХЗ-ын хурдасгуур зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх зэрэг юм.


2023-2027 онд хэрэгжүүлэх НҮБ-ын ТХХАХ-ийн тэргүүлэх чиглэл, хүлээгдэж буй үр дүнгийн зорилтууд болон ТХЗ-ын 12 хурдасгуурын уялдааг Зураг 10-д үзүүлээ. Үүнээс ажиглахад НҮБ-ын 2023-2027 оны ТХХАХ-ний хүлээгдэж буй үр дүнгийн зорилтууд нь ТХЗ-ын 12 хурдасгуур зорилтуудтай нийцэж байна. Үүнээс үзэхэд НҮБ-ын ТХХАХ-ийн тэргүүлэх чиглэл, үр дүнгийн зорилтуудын түвшинд өөрчлөлт хийх шаардлагагүй байна. Гэхдээ эдгээр ТХЗ-ын хурдасгуур зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт үр дүнтэй дэмжлэг үзүүлэхийн тулд НҮБ-ын Удирдлагын баг нь Хамтарсан ажлын төлөвлөгөөний (ХАТ) холбогдох дэд зорилтуудыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх, хэрэгжилтийг нь эрчимжүүлэх шаардлагатай.



Монгол Улс 2023 онд ТХЗ-ын хэрэгжилтийн талаарх Үндэсний сайн дурын хоёрдугаар илтгэлээ НҮБ-ын Дээд хэмжээний чуулганд танилцууллаа. © ЭЗХЯ

⁶³ <https://hlpf.un.org/sites/default/files/vnrs/2023/VNR%202023%20Mongolia%20Report.pdf>

Зураг 10. НҮБ-ын ТХХАХ-ийн тэргүүлэх чиглэл, хүлээгдэж буй үр дүнгийн зорилтууд, ТХЗ-ын 12 хурдасгуурын уялдаа



6.2**ТХЗ-ыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бусад үйл ажиллагаа**

2023 оны 11-р сард Гадаад харилцааны дэд сайд ахалсан Монголын төлөөлөгчид Ази, Номхон далайн бүсийн Хүн ам, хөгжлийн асуудлаарх 7-р Бага хуралд оролцов. Чуулганы үеэр Монгол Улсын Засгийн газар Хүн ам, хөгжлийн олон улсын бага хурлаас дэвшүүлж буй үйл ажиллагааг тууштай дэмжиж ажиллахаа дахин нотолсон.⁶⁴

Шүүгч, хуульчийн хараат бус байдлын асуудал эрхэлсэн НҮБ-ын Тусгай илтгэгч Маргарет Саттертуэйт 2023 оны 11-р сард Монгол Улсад албан ёсны айлчлал хийсэн. 2004 оноос хойш тусгай журмын мандат бүхий 12 тусгай илтгэгч Монгол Улсад айлчилсан. Тусгай илтгэгч Монгол Улс нотолгоонд суурилж шинэчлэл хийж буй хандлагыг сайшаахын сацуу хүний эрхийг суурь үндэс болгосон хараат бус шүүхийн тогтолцоог бэхжүүлэх чиглэлээр дорвитой арга хэмжээ авахыг уриалсан. Шүүх эрх мэдлийн бие даасан, хараат бус байдлыг хангахад төсвийн санхүүжилт хангалттай байх нь зайлшгүй чухал болохыг тэмдэглэсэн. 2019 онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шүүхийн төсвийг зөвхөн УИХ-ын Хууль зүйн байнгын хороо хянан хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлэх эрх зүйн шинэчлэлийг баталсан. Гэвч энэ заалт одоо болтол бүрэн хэрэгжээгүй байна. Тусгай илтгэгч энэ

хуулийн хэрэгжилтийг бүрэн хангахад чиглэсэн арга хэмжээ авахыг Засгийн газраас хүссэн. Шүүхийн жишиг төсвийг улсын төсвийн хоёр хувьтай тэнцэх хэмжээнд тогтоох саналыг Шүүхийн ерөнхий зөвлөл УИХ-д өргөн бариад байна.

Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэхийн тулд прокурорын байгууллагыг дотоод хяналт, гадны нөлөөлөл, зохисгүй хөндлөнгийн оролцооноос хамгаалах чиглэлээр хууль эрх зүйн өөрчлөлт хийх шаардлагатай байна. Монгол Улсад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд яллах, өмгөөлөх эрхийг тэнцвэржүүлэх, мэтгэлцээнийг бэхжүүлэх, талуудын тэгш байдлыг хангах чиглэлээр сайжруулах боломж байгааг Тусгай илтгэгч тэмдэглэсэн. Судалгааны⁶⁵ дүн шүүх засаглалд итгэх олон нийтийн итгэл сул байгааг харуулсан. Шүүхэд итгэх олон нийтийн итгэл сул байгааг судалгаа харуулж, олон нийтийн сүлжээгээр шүүгчдийн нэр хүндэд халдах, нөлөөлөх оролдлого гардаг, ялангуяа төрийн өндөр албан тушаал хашиж буй хүмүүсээс ийм төрлийн дайралт ирж байгааг сонсоод Тусгай илтгэгч эмзэглэж буйгаа илэрхийлсэн. Тэрээр шүүх засаглалд итгэх олон нийтийн итгэлийг сэргээхэд анхаарч арга хэмжээ авахыг Засгийн газарт уриалсан.

⁶⁴ [https://www.unescap.org/sites/default/d8files/event-documents/MN_7APPC_Item2\(2\).pdf](https://www.unescap.org/sites/default/d8files/event-documents/MN_7APPC_Item2(2).pdf)

⁶⁵ Open Society Forum NGO; Intellectual Innovation NGO: Mongolia: "Court Index 2021" Survey report, 2022 <http://judindex.forum.mn/>

ДҮГНЭЛТ

2023 он бол Монгол Улс дахь НҮБ-ын 2023-2027 оны НҮБ-ын ТХХАХ-ийг хэрэгжүүлж эхэлсэн анхны жил байлаа. Түүнчлэн Монгол Улс ТХЗ-ийн хэрэгжилтийн хоёр дахь удаагийн ҮСДИ-ээ боловсруулж ТХЗ-ын хэрэгжилтэд гарсан ахиц дэвшил, сорилтуудыг дүгнэж, үндэсний хөгжлийн тэргүүлэх гурван зорилт, ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах 12 тэргүүлэх чиглэлийг тодорхойлж амжилттай ажилласан.

НҮБ-ын 2023-2027 оны ТХХАХ-ний хүлээгдэж буй үр дүнгийн зорилтууд нь ТХЗ-ын хэрэгжилтийг хурдасгах 12 тэргүүлэх чиглэлийн зорилтуудтай нийцэж байгаа болно. Энэ нь НҮБ-ын ТХХАХ-ний тэргүүлэх чиглэл, үр дүнгийн зорилтуудын түвшинд өөрчлөлт хийх шаардлагагүйг илэрхийлж байна.

Гэхдээ эдгээр ТХЗ-ын хурдасгуур зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт үр дүнтэй дэмжлэг үзүүлэхийн тулд НҮБ-ын Удирдлагын баг нь Хамтарсан ажлын төлөвлөгөөний (ХАТ) холбогдох дэд зорилтуудыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэх, хэрэгжилтийг нь эрчимжүүлэх шаардлагатай.

Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөв байдлын шинжилгээнд туссан 2023 онд шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээнд үндэслэн 2024 он болон түүнээс цааши хугацаанд Хамтарсан Ажлын Төлөвлөгөөнд туссан хүлээгдэж буй үр дүнгийн дэд бүлгүүдийн дараах чиглэлд тэргүүлэх анхаарал хандуулж ажиллах шаардлагатай. Үүнд:

- Цахим хөгжил, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих замаар эдийн засгийг төрөлжүүлж Монгол Улс дижитал нийгэм, эдийн засагт шилжих, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах, уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх;
- Сэргээгдэх эрчим хүчинд шилжих замаар агаарын бохирдлоос үүдэлтэй эрүүл мэндийн эрсдэл, уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан гамшгийн эрсдэлийг бууруулах, биологийн олон янз байдлыг хамгаалах замаар экологийн тэнцвэртэй байдлыг хангах;
- Төрийн үйл ажиллагаа, үйлчилгээний хариуцлага, ил тод, тогтвортой байдлыг сайжруулах замаар засаглалыг бэхжүүлэх;
- Хөдөө, хотын хөгжлийн ялгааг багасгах, хөдөөгийн хүн амын амьжиргааг сайжруулах зорилго бүхий бүсчилсэн хөгжил, хөдөөгийн хөгжлийг дэмжих чиглэлээр Монгол Улсын Засгийн газарт дэмжлэг үзүүлэх;
- Ядуурлыг бууруулах, хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг чанд баримтлан хувийн хэвшлийг хөгжүүлж зохистой ажлын байрыг олноор бий болгох, залуучуудад хөгжих өргөн боломжийг бүрдүүлж тэднийг чадавхжуулах, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлж жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэх.

Монгол Улсын хөгжлийн төлөв байдлын шинжилгээний ажлын хэсэг нь Монгол Улс дахь НҮБ-ын Удирдлагын Багийн стратегийн удирдлага дор улс оронд шинээр үүсч буй нөхцөл байдалд


тогтмол хяналт шинжилгээ хийж, НҮБ-ын ТХХАХ-ний хэрэгжилтэд нөлөөлөх аливаа асуудлын талаарх мэдээллээр НҮБ-ын Удирдлагын Багийг цаг тухайд нь хангаж ажиллах шаардлагатай.

ТОВЧИЛСОН ҮГС

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн хөгжлийн банк
АТИ	Авилгын төсөөллийн индекс
АН	Ардчилсан нам
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БОЯБК	Биологийн олон янз байдлын конвенц
БОЯБҮСҮАТ	Биологийн олон янз байдлын үндэсний стратеги үйл ажиллагааны төлөвлөгөө
БЖДҮ-ҮҮД	Бичил, жижиг, дунд үйлдвэрүүд
ВУАХ	Венийн Үйл ажиллагааны хөтөлбөр
ГШХО	Гадаадын шууд хөрөнгө оруулалт
ГЭБСЧ	Гамшгийн эрсдэлийг бууруулах
ДГХБО	Далайд гарцгүй хөгжиж буй орнууд
ДГХБООУБСТ	Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын Олон улсын бодлогын судалгааны төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДХТХ	Дунд хугацааны төсвийн хүрээ
ДОЯБХ	Дэлхийн биологийн олон янз байдлын хүрээ
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗҮАХБСБ	Зүүн Өмнөд Азийн хуулийн байгууллагуудын сүлжээ байгууллага
ЖЭТБЭЭМ	Жендэрийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийг эрх мэдэлжүүлэх
ЖДҮ	Жижиг, дунд үйлдвэрүүд
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ЛГБТКИ+	Лесбиян, гей, бисексуал, трансжендер, кюиир, интерсекс
МАН	Монгол ардын нам
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУ НҮБУБ	Монгол Улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын Удирдлагын баг
НД-ДДДЗС	Нотр Дамын Даян дэлхийн дасан зохицох санаачилга
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБ-ын ХБХЭТК	НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай
НҮБ-ын ХХААБ	НҮБ-ын Хүнс, хөдөө ахуйн байгууллага
НҮБ-ын ЦТК	НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенц
НҮБ-ын АЭК	НҮБ-ын Авлигын эсрэг конвенц
НҮБ-ын ХХБХ	НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал
НҮБ-ын ХХ	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
НҮБ-ын АНДБЭЗНК	НҮБ-ын Ази, Номхон далайн бүсийн эдийн засаг,


НҮБ-ын БШУСБ	НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага
НҮБ-ын СЗГ	НҮБ-ын Суурин зохицуулагчийн газар
НҮБ-ын ХАС	НҮБ-ын Хүн амын сан
НҮБ-ын ХС	НҮБ-ын Хүүхдийн сан
НҮБ-ын МБГХТА	НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба
НҮБ-ын ТХХАХ	НҮБ-ын Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны хүрээ
НҮБ-ын ҮДЗБГХЭК	НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэргийн эсрэг конвенц
ОУХБ	Олон улсын хөдөлмөрийн байгууллага
ОУШХБ	Олон улсын шилжих хөдөлгөөний байгууллага
ОУХТ	Олон улсын худалдааны төв
ОХЯИ	Олон хэмжээст ядуурлын индекс
СЯ	Сангийн яам
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын Их Хурал
УХОХ	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр
ҮСДИ	Үндэсний сайн дурын илтгэл
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар
ҮЭС	Үндэсний экспортын стратеги
ҮТХН	Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилт
ТХЗ	Тогтвортой хөгжлийн зорилгууд
ТХҮЗ	Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл
ТХТӨТЗ	Тогтвортой хөгжлийн төлөөх олон талт зөвлөл
ТХУТӨТЧ	Тогтвортой хөгжлийн асуудлаарх Улс төрийн өндөр түвшний чуулган
ХАТ	Хамтарсан ажлын төлөвлөгөө
ХБТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хууль
ХБТТУТХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХТБШ	Хөгжлийн төлөв байдлын шинжилгээ
ХХ	Хүлэмжийн хий
ХАХОУБХ	Хүн ам, хөгжлийн асуудлаарх олон улсын Бага хурал
ХХИ	Хүний хөгжлийн индекс
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ШХАБ	Шанхайн Хамтын ажиллагааны байгууллага
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭМТБ	Эрүүл мэндийн төлөөх байгаль орчин

© Монгол Улс дахь
Нэгдсэн Үндэстний Байгууллага 2024

 НҮБ-ын байр,
Нэгдсэн Үндэстний гудамж-14,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот
14201, Монгол Улс

 unmongolia

 unmongolia

 <https://mongolia.un.org>

 +976-11-327585